



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ



Түмэд

Доржрэнцэнгийн АЛТАНГЭРЭЛ

**МОНГОЛ УЛС ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ
БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
АСУУДАЛ: (ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЖИШЭЭН ДЭЭР)**



Мэргэжлийн индекс

D042101

Эрх Зүйн бакалаврын

зэрэг горилсон

Дипломын төсөл

Удирдсан

Ахлах багш Т.Наранцогт /MSc/

Улаанбаатар. 2022.



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ



Түмэд

Доржрэнцэнгийн АЛТАНГЭРЭЛ

**МОНГОЛ УЛС ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ
БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
АСУУДАЛ: (ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЖИШЭЭН ДЭЭР)**

В Мэргэжлийн индекс

D042101

Эрх Зүйн Бакалаврын Зэрэг

Горилсон Дипломын Төсөл

Удирдагч: Ахлах багш Т.Наранцогт
/MSc/

Шүүмжлэгч: / /

Улаанбаатар. 2022

АГУУЛГА

ОРШИЛ

- Сэдвийг сонгосон үндэслэл
- Судалгааны ажлын зорилго, зорилт
- Судалгааны арга зүй
- Ном зүйн байдал буюу судлагдсан байдал

I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

Чөлөөт бүсийн үүсэл хөгжил, төрөл:

- 1.1** Эдийн засгийн чөлөөт бүсийн онцлог
- 1.2** Эдийн засгийн чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын орчин, түүний онцлог

II БҮЛЭГ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

- 2.1** Монгол Улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчин
- 2.2** Чөлөөт бүс дэх төлбөр тооцооны төлөв байдал
- 2.3** Чөлөөт бүсийн тээвэр ложистик
- 2.4** Харьцуулалт /БНХАУ-ын болон Казахстан улсын чөлөөт бүс/

ДҮГНЭЛТ

- Санал, зөвлөмж
- Ном зүй
- Хавсралт

ХҮСНЭГТҮҮДИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Эдийн засгийн чөлөөт бүсийн төрөл
- Хүснэгт 2. Эдийн засгийн чөлөөт бүс
- Хүснэгт 3. Тээврийн салбарын бүтээгдэхүүн
- Хүснэгт 4. Логистикийн салбарын өнөөгийн байдал
- Хүснэгт 5. Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийн журмын бүтэц
- Хүснэгт 6. Казакстан улсын эдийн засгийн онцгой бүс, Аж үйлдвэрийн бүсийн хуулийн бүтэц
- Хүснэгт 7. Эдийн засгийн онцгой бүсийн хуулийн харьцуулалт /БНХАУ, Монгол

улс/

ЗУРГУУДЫН ЖАГСААЛТ

Зураг 1. Эдийн засгийн чөлөөт бүсийн яалгаа

Зураг 2. Замын-Үүд чөлөөт бүс

Зураг 3. Замын-Үүд чөлөөт бүсийн тээвэр ложистикийн төлөвлөлт

Зураг 4. Замын-Үүд чөлөөт бүсийн тээвэр ложистикийн урсгалын байршил

Зураг 5. БНХАУ-ын Эрээн хот, МУ-ын Замын-Үүд чөлөөт бүсийн төлөвлөлт

Зураг 6. БНХАУ Эрээн хотын чөлөөт бүсийн төлөвлөлт

Зураг 7. МУ-ын тээврийн тогтолцоо

Зураг 8. Торгоны замын зураглал

Зураг 9. Эдийн засгийн онцгой бүсийн оролцогчид

ТОВЧИЛСОН ҮГС, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

ЭЗОБ- Эдийн засгийн онцгой бүс

ЭЗЧБ- Эдийн засгийн чөлөөт бүс

ХЧБ- Худалдааны чөлөөт бүс

ДХБ-Дэлхийн худалдааны байгууллага

GATT- General Agreement of Trade and Tariff

FTA- Том чөлөөт худалдааны бүс

FTZ- Жижиг чөлөөт худалдааны бүс

NAFTA-Хойд Америкийн чөлөөт худалдааны бүс

CEFTA буюу Төв Европын чөлөөт худалдааны бүс

AFTA- Зүүн Өмнөд Азийн чөлөөт худалдааны бүс

ОРШИЛ

Сэдвийг сонгосон үндэслэл

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлалыг 1995 онд баталж чөлөөт бүс байгуулах үндэслэл, шаардлага, онцлог зарчим, угтвар нөхцөл, баримтлах шалгуур үзүүлэлтийг тодорхойлон өдгөө хүртэл гурван чөлөөт бүс байгуулахаар хууль батлан тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн боловч бодит байдал дээр чөлөөт бүсээ жинхэнэ утгаар байгуулж чадаагүй байна. Чөлөөт бүсийг газар зүйн хувьд оновчтой байршилд байгуулан гадаад худалдааны эргэлтийг сайжруулах, экспортыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар тухайн улс эдийн засгийн олон талын үр ашгийг хүртдэг. Чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлж чадсан улсуудын ихэнх нь далайн боомт болон бусад улстай хил залгаа эдийн засгийн ач холбогдолтой цэгийг сонгон байгуулдаг. Монгол Улсын хувьд газар зүйн байрлалын хувьд хоёр улстай хиллэдэг, далайд гарцгүй зэрэг онцлогоо харгалзан Оросын Холбооны улстай хиллэдэг Алтанбулаг болон Цагааннуур боомт, Бүгд Найрамдах Хятад Ард улстай хиллэдэг Замын-Үүд боомтод тулгуурлан чөлөөт бүс байгуулсан. Чөлөөт бүсийн үйл ажиллагаа амжилттай явагдахад төрийн бодлого, орон нутгийн оролцоо, бизнес эрхлэгч буюу хөрөнгө оруулагчийн дэмжлэг маш чухал тулгуур хүчин зүйл болдог бөгөөд Монгол Улсын хувьд чөлөөт бүсийг байнгын ажиллагаатай болгох, хөгжүүлэх зэргээр бодлогын түвшинд зорьж буй боловч одоог хүртэл зарим нэг асуудал тодорхой бус, хууль эрх зүйн орчин зохицуулалтгүй орхигдсон хэвээр байна. Тодруулбал, чөлөөт бүсэд төлбөр тооцоо гүйцэтгэх мөнгөн тэмдэгт, банк, санхүүгийн байгууллагыг хэрхэн байгуулах, аль улсын банкиг байгуулах зэрэг асуудал тодорхой бус байсаар байна. Мөн манай улсын хувьд тээвэр ложистикийн салбар хангалттай сайн хөгжөөгүйн улмаас чөлөөт бүсэд нэвтрэх барааг хэрхэн тээвэрлэх, түргэн шуурхай ачих, хадгалалтын агуулах хэрхэн байгуулах, тээвэр ложистикийн нэгдсэн төвийг байгуулах боломжтой эсэх талаар судлах шаардлагатай байна.

Судалгааны ажлын зорилго, зорилт

- **Зорилго:** Монгол Улсын чөлөөт бүс, тэдгээрийн эрх зүйн асуудлууд, тэр дотроос төлбөр тооцоог хэрхэн гүйцэтгэх журам, банк, санхүүгийн байгууллагыг хэрхэн байгуулах болон тээвэр ложистикийн нэгдсэн төв байгуулах эрх зүйн зохицуулалтыг гадаад орны сайн туршлагатай харьцуулан судлах замаар асуудлыг хөндөхийг зорьсон.
- **Түлхүүр үг:** Эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүй, тээвэр ложистик, төлбөр тооцоо

- **Зорилт:**

- Чөлөөт бүсийн орчин, эрх зүйн байдлыг судлах
- Тээвэр ложистикийн үйл ажиллагаа хэрхэн явагддаг, нөхцөл байдал, эрх зүйг судлах
- Санхүүгийн төлбөрийг хэрхэн гүйцэтгэх, чөлөөт бүсийн онцлогыг судлах
- Хэрэглэгч, хөрөнгө оруулагчид таатай орчин нөхцөл бүрдүүлэх эрх зүйн орчныг судлах

Судалгааны арга зүй

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар;
- Чөлөөт бүсийн өнөөгийн байдлын талаар;
- Ачаа тээврийн үйлчилгээний зохион байгуулалт, зохицуулалт, хэтийн төлвийн чиглэлээр
- Тухайн ажлыг эхлэхийн өмнө хийгдэж байсан судалгааны ажлын статистик мэдээлэл, тайланг цуглуулна. Мөн холбогдох олон улсын цахим хуудсанд нэвтрэн интернет судалгаа, статистик мэдээ, тайланг авах;
- БНХАУ-ын сайн туршлагыг судлах;

Ном зүйн тойм буюу судлагдсан байдал

Өнөөдрийн байдлаар Монгол улсын чөлөөт бүсийн хөгжилд тулгамдаж буй асуудал, хөгжилд нөлөөлөх хүчин зүйл зэрэг асуудлыг хөндөж судалсан судалгаа, нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл гарсаар байна. Уг судалгааны ажилд чөлөөт бүсийн ангилал, чөлөөт бүс байгуулах байршил, чөлөөт бүсийн хөгжил, эдийн засгийн үр өгөөжийн талаас судалсан байна. Дээрх судалгааны материалуудыг судлахад Монгол улс чөлөөт бүсийн тухай хууль баталж, Замын-Үүд чөлөөт бүс, Алтанбулаг чөлөөт бүс, Цагааннуур чөлөөт бүсийг тус тус байгуулсан боловч зохих ёсоор байгуулагдаагүй, уг чөлөөт бүсүүдийг ажиллагаанд оруулах, хөгжүүлэх, дэлхийн сайн жишигт орнуудтай адил хэмжээнд хүргэх зэрэг асуудлыг хөндсөн байсан.

Энэ судалгааны ажлын хүрээнд Монгол улсын чөлөөт бүсэд төлбөр тооцоог аль улсын мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх, бэлэн бус гүйлгээ, шилжүүлэг хийх эрхтэй тусгай зөвшөөрөлтэй этгээд болох банк, санхүүгийн байгууллагыг хэрхэн байгуулах, аль улсын банкиг байгуулах зэрэг асуудал тодорхой бус, эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Мөн чөлөөт бүсэд байрших бараа таваарыг ачих, тээвэрлэх тээвэр ложистикийн нэгдсэн төв байгуулах боломжтой эсэх, тээвэр ложистикийг чөлөөт бүсэд хөгжүүлснээр цаашид гарах давуу талыг хөндөн гаргаж ирэх болно.

Зохиогчийн нэр	Хэвлэгдсэн он	Сэдвийн нэр	
О.Хишигмөнх	2018 он	Монгол улсын чөлөөт бүсийн хөгжилд тулгамдсан зарим асуудал	
Н.Отгонсайхан	2018 он	Монгол улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс байгуулах урьдчилсан нөхцөл, боломж	
Д. Ганбаатар	2009 он	Чөлөөт бүсийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа	
“Сентрополис” ХХК	2016 он	“Замын-Үүд” болон Эрээний боомтын хооронд хил дамнасан чөлөөт бүс байгуулах ажлын урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэл	
Ц.Дарь		Чөлөөт бүсийн түүхэн хөгжил, нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг	
Dr. Meng, Guangwen	2005 он	China’s model of free economic zones: experiences and prospects after over 20 years	
Ж.Эрдэнэбулган Т.Наранцогт Х.Болормаа А.Солонго МУИС, ХЗС	2017 он	МУ-ын хууль тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр нөлөөг боловсронгуй болгох зарим арга зам <i>Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн судалгааны тойм</i>	
José Cerón The Ministry of Industry and Trade and the U.S. Agency for International Development	2004 он	Assessment of Mongolia’s free trade zone program and site evaluation	

I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. Чөлөөт бүсийн үүсэл хөгжил, төрөл

Чөлөөт бүс гэдэг нь нэгэн улсын хил дотор оршинх боловч гаалийн хилд ордоггүй нутаг дэвсгэр юм. Өөрөөр хэлбэл, чөлөөт бүс нь тус улсын үндсэн хуулиар заасан нутаг дэвсгэрт хамаарах боловч, тухайн улсын нутаг дэвсгэрт үйлчилж буй худалдаа, эдийн засаг болон санхүүгийн хууль тогтоолууд нь чөлөөт бусад хамааралгүй нутаг дэвсгэр юм.

Дэлхийн чөлөөт худалдааны бүсийн үүсэл 13 дугаар зууны үед Франц улсын Масай худалдааны боомтоос эхлэлтэй. Үүнээс хойш Европын олон орон далайн боомт газруудад чөлөөт худалдааны боомт нээж, худалдааг чөлөөтэй эрхэлж байжээ.

Харин одоогийн орчин үеийн ойлголт, тодорхойлолт бүхий чөлөөт бүс нь анх 18 дугаар зууны дунд үед Англи улсад байгуулагдсан байна. Англи улс чөлөөт худалдааны талаар төрөл бүрийн бодлого хэрэгжүүлж, улмаар чөлөөт худалдааны суурь бүхий Европ тивд чөлөөт худалдаа хурдацтай хөгжсөн.

1936 онд АНУ нь Нью-Йорк мужийн Бруклинд анхны чөлөөт худалдааны бүсээ байгуулсан.

20 дугаар зууны дунд үеэс бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох асуудалд анхаарал хандуулснаар чөлөөт худалдааны бүс нь экспорт-үйлдвэрлэлийн бүс болох эхлэл тавигдсан. 20 дугаар зууны сүүл үеэс технологийн хөгжлийг даган шинэ, өндөр хөгжлийн технологи бүхий чөлөөт бүс байгуулагдаж эхэлжээ. Улмаар дэлхийн өнцөг булан бүрт хэдэн зуу, мянган чөлөөт худалдааны бүс үйл ажиллагаагаа явуулж байна.

Гадаад худалдааны бодлогод дараах хоёр үзэл хандлага байдаг¹:

- 1.Фритредерство буюу чөлөөт худалдаа²;
- 2.Протекционизм буюу хамгаалах худалдаа

Чөлөөт худалдааны бодлого гэдэг нь нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бараа, зэвсэг, хар тамхи зэргийг импортлохыг хориглох бодлого явуулах

¹ Д.Батсүх, “Олон улсын худалдаа, чөлөөт бүс ба гадаадын хөрөнгө оруулалт”, (Улаанбаатар хот, 2006 он, “Шувуун саарал” ТӨААТҮГ), 6 дугаар тал

² А.Смит, Д.Рикардо нарын үзэл хандлага
Ж.Стюард Миллийн үзэл хандлага

Хамгаалах худалдааны бодлого нь нийгэм, эдийн засагт хор хөнөөлгүй ердийн бараа, ажил, үйлчилгээний худалдаанд эдийн засгийн болон эдийн засгийн бус саад хориг тавихыг хэлдэг.

Чөлөөт бүсийг байгуулахын хамгийн гол зорилго нь экспортын чиглэлийн үйлдвэрүүдийг дэмжих юм. Чөлөөт бүсэд байрлалтай үйлдвэр, аж ахуй нэгжүүдийг татвараас чөлөөлөх арга хэмжээ авдаг. Мөн чөлөөт бүсэд олсон орлогоо шууд улсын бусад нутаг дэвсгэр болон гадаад улс руу шилжүүлэх боломжтой. Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэр худалдааны маш олон хөнгөлөлт үзүүлдэг болохоор шинээр үйлдвэр нэвтрүүлэн хөгжүүлэхэд хамгийн тохиромжтой газар байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, шинээр үйлдвэр нээн хөгжүүлэхэд саад бэрхшээл, хүндрэл багатай тул гадаадын хөрөнгө оруулагчид тус бүс нутагт илүү их хөрөнгө оруулалт хийх боломжтой болдог тул тус улс оронд шинэ технологи нэвтрэх давуу тал бий болдог.

Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн, аялал-жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн чөлөөт бүс гэсэн хэлбэрүүдтэй.

● **Худалдааны чөлөөт бүс:** Худалдааны чөлөөт бүсэд бараа, бүтээгдэхүүний мөн чанарыг нь алдагдуулахгүйгээр хадгалах, хамгаалах, түүний сав баглаа, боодлыг сайжруулах, борлогдох чанарыг дээшлүүлэх, борлуулах үйл ажиллагааг хэлнэ. Чөлөөт худалдааны бүсүүд нь дэлхийд өргөн тархсан байдаг. АНУ-д энэ нь ихээхэн хөгжсөн. Худалдааны зардлыг хэмнэх худалдааны үйл ажиллагааг хурдасгах худалдааг дэмжих зорилгоор 1934 оноос АНУ-ын тусгай хуулиудад чөлөөт худалдааны бүсүүдийг байгуулахыг тусгасан байдаг.

Эдгээр бүсүүд нь АНУ-ын ерөнхий аж ахуйн үйл ажиллагааны журамтай харьцуулах юм бол аж ахуйн үйл ажиллагааныхаа түүнчлэн гадаад эдийн засгийн ажиллагааныхаа хүрээнд хөнгөлөлттэй журам тогтоолгосон АНУ-ын нутаг дэвсгэрийн хязгаарлагдмал хэсгүүд юм. Хуулиар албан ёсны боомт хотуудад нэг юмуу хэд хэдэн гадаад худалдааны чөлөөт бүсүүд байгуулж болохыг тогтоож өгсөн. 1960-д оны дунд үеэс хөгжиж буй орнуудад гадаадын капитал ихээр орж ирсэн.

● **Үйлдвэрлэлийн чөлөөт бүс:** Үйлдвэрлэлийн чөлөөт бүсэд тэргүүний, дэвшилтэт технологи бүхий, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.

● **Хөдөө аж ахуйн чөлөөт бүс:** Хөдөө аж ахуйн чөлөөт бүсэд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий үйлчилгээний цогцолбор бүрдүүлж, бүх төрлийн үйлчилгээ эрхэлнэ.

- **Аялал жуулчлалын чөлөөт бүс:** Аялалжуулчлал-үйлчилгээний чөлөөт бүсэд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий үйлчилгээний цогцолбор бүрдүүлж, бүх төрлийн үйлчилгээг эрхэлнэ.

- **Эдийн засгийн чөлөөт бүс:** Эдийн засгийн чөлөөт бүсэд бусад хэлбэрийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг хосолсон буюу нэгтгэсэн байдлаар эрхэлнэ. Шинжлэх ухааны нийтлэл болон олон улсын байгууллагын тайланд төрөл бүрийн бүсийн тодорхойлолтод. “Эдийн засгийн чөлөөт бүс” гэсэн тодорхойлолт, ухагдахууныг хэрэглэдэг.

Дээрх чөлөөт бүсийн төрлүүдээс эдийн засгийн чөлөөт бүсийн талаар дэлгэрэнгүй авч үзье. Учир нь манай улсад эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүс байгуулагдсан бөгөөд энэ судалгааны ажлыг Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа, эрх зүйн орчны хүрээнд явуулсан болно.

1.2. Эдийн засгийн чөлөөт бүс

20 дугаар зууны II хагасаас олон улсын эдийн засгийн харилцааны салшгүй хэсэг нь “эдийн засгийн чөлөөт бүс” болж эхэлсэн.

Эдийн засгийн чөлөөт бүс нь хөнгөлөлт болон урамшууллын онцгой системийг багтаасан, тус улсын бусад хэсэгт үл хэрэглэгдэх, үндэсний эдийн засгийн орон зайн нэг хэсэг нь байдаг. Зарим улсад чөлөөт бүсийг өөрийн бүсийн ажилтнуудын амьдралын түвшин, нөхцөл гэх мэт хүчин зүйлээс хамааран “эдийн засгийн тусгай зориулалтын бүс” гэх нэр томъёог ашигладаг.

Эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах зорилго нь:

- улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин;
- улс ардын аж ахуйг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө зэргээс хамааран ялгаатай байдаг.

Эдийн засгийн чөлөөт бүсийг бий болгох дээр дурдсан үндсэн шалтгаан, зорилгоос гадна дараах гурван үүрэг бий:

1.Экспортын үйлдвэрлэлийг урамшуулсны үндсэн дээр валютын эх үүсвэртэй болох;

2.Эдийн засагт эзлэх байр суурь, ажлын байрыг өсгөх;

3. Аж ахуйг эзэмших шинэ аргыг эдийн засгийн чөлөөт бүсэд туршиж, үр дүнд нь үндэсний аж ахуйн өсөлтийг нэмэгдүүлэх³.

Эдийн засгийн чөлөөт бүсийн төрөл, түүний үндсэн шинж:

Эдийн засгийн чөлөөт бүс нь дараах төрөлтэй байна:⁴

Хүснэгт 1. Эдийн засгийн чөлөөт бүсийн төрөл

1. Худалдааны чөлөөт бүс:	2. Аж үйлдвэрлэлийн чөлөөт бүс:	3. Техник нэвтрүүлэлтийн чөлөөт бүс:
1. Гаалийн чөлөөт; 2. Бондын агуулах; 3. Чөлөөт боомтын; 4. Худалдаа-үйлдвэрлэлийн.	1. Импорт орлуулалтын; 2. Экспортын баримжаат; 3. Аж үйлдвэрлэлийн парк; 4. Шинжлэх ухаан, аж үйлдвэрлэлийн парк; 5. Экспорт-импорт орлуулалтын.	1. Техникийн бодлогын; 2. Техникийн парк; 3. Шинэчлэлийн төв.
4. Цогцолбор чөлөөт бүс:	5. Олон улсын эдийн засгийн чөлөөт бүс:	
1. Чөлөөт үйлдвэр эзэмших бүс /Баруун Европ, Канад/; 2. Хятадын эдийн засгийн тусгай бүс; 3. Газар нутгийн онцгой дэглэм /Бразил, Аргентин/; 4. Онцгой эдийн засгийн бүс /Орос/.	1. Туманган чөлөөт эдийн засгийн бүс; 2. Хил орчмын чөлөөт эдийн засгийн бүс; 3. Европын бүс нутгийн.	

Эдийн засгийн чөлөөт бүсийн зохион байгуулалт, үйл ажиллагааны бүтэц нь олон янз тул заримдаа аль нэг чөлөөт бүсийг тодорхой төрөлд хамааруулах нь хялбар биш, олон бүсийн шинжийг өөртөө агуулсан байдаг. Эдийн засгийн чөлөөт бүсийг зохион байгуулахад

- нутаг дэвсгэрийн ба
- үйл ажиллагааны /цэгийн/ гэсэн ялгаатай хоёр хандлагыг ашигладаг.

³ Д.Батсүх, “Олон улсын худалдаа, чөлөөт бүс ба гадаадын хөрөнгө оруулалт”, 174 дүгээр тал

⁴ Д.Батсүх, “Олон улсын худалдаа, чөлөөт бүс ба гадаадын хөрөнгө оруулалт”, 177 дугаар тал

Хүснэгт 2. Эдийн засгийн чөлөөт бүс

Хэмжээ, байгууллагын чадвараас хамаарсан эдийн засгийн чөлөөт бүс				
Нутаг дэвсгэрийн:	Үйл ажиллагааны /дэглэм, журмын/			
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт	Аж үйлдвэр, шинжлэх ухааны парк	Худалдаа, агуулахын цогцолбор	Задгай тэнгисийн бүсийн санхүүгийн төв	Цэгүүд /байгууллагын/

Нутаг дэвсгэрийн хандлагаар чөлөөт бүсэд байгаа бүх үйлдвэрт аж ахуйн үйл ажиллагааны хөнгөлөлттэй журмыг ашигладаг онцгой нутаг дэвсгэр гэж үздэг.

Үйл ажиллагааны хандлагаар чөлөөт бүс гэдэг нь аж ахуйн нэгж хаана байрлаж байгаагаас үл хамааран худалдаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тодорхой төрөлд хөнгөлөлттэй журам хэрэглэхийг хэлдэг.

1.3. Эдийн засгийн чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын орчин, түүний онцлог

Эдийн засгийн хөнгөлөлтийг дараах дөрвөн бүлэгт ангилдаг:

1. Гадаад худалдааны хөнгөлөлт: Гааль, татварын онцлог журам, гадаад худалдааны үйл ажиллагааг хялбаршуулсан дарааллаар гүйцэтгэх;
2. Татварын хөнгөлөлт: Үйлдвэрлэл эрхлэгчдийн зан байдал буюу тодорхой төрлийн үйл ажиллагааг татвараар урамшуулах хэм хэмжээг агуулдаг;
3. Санхүүгийн хөнгөлөлт: Ахуй үйлчилгээний хямд үнэ, газар болон үйлдвэрлэлийн талбайн түрээсийн хямд төлбөр, хөнгөлөлттэй зээл болон бусад боломжоор хангадаг;
4. Засаг захиргааны хөнгөлөлт: Бүсийн засаг захиргааны үйлдвэрлэл, бүртгэлийн ажил ба гадаад иргэдийн хил гарах, орох журам, дүрмийг аль болохоор хялбар байлгах зохицуулалт.

Эдийн засгийн чөлөөт бүсийн хөнгөлөлт нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал хүчин зүйл болдоггүй бөгөөд хөнгөлөлт, урамшууллын тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын баталгаа, дэд бүтцийн чанар, мэргэжилтэн, ажиллах хүч, засаг захиргааны хүнд суртлыг хялбаршуулах зэрэг нь голлох нөлөө үзүүлдэг.

Эдийн засгийн чөлөөт бүс нь төр болон зах зээл хоорондын зөвшилцөл юм. Эдийн засгийн чөлөөт бүсийг худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлах үйл явцыг дэмжигч гэж үзэж болох ч үүнийг тодорхой хугацаанд эрх мэдэл бүхий төрийн байгууллагын хатуу хяналтан дор хязгаарлагдмал эрх мэдлийн хүрээнд зөвшөөрдөг билээ.⁵

1.4 Том чөлөөт худалдааны бүс буюу “FTA”

“FTA” нь хууль зүйн зохицуулалтын хувьд ДХБ-аас батлагдсан, гишүүн улсад мөрдөгддөг Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (General Agreement of Trade and Tariff)-ийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу байгуулагдаж, ДХБ-ын хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрдөг онцлогтой бүс юм.⁶ Том чөлөөт худалдааны бүс буюу “FTA” нь хоёр ба түүнээс дээш улс болон бие даасан гаалийн баталгаат бүс худалдааны татварын болон татварын бус хязгаарлалт, үйлчилгээний салбарын зах зээлд нэвтрэх (market access) хязгаарлалтыг бууруулах, гадаад худалдааг нээлттэй болгох зорилгоор хамтран байгуулсан тодорхой хил хязгаар бүхий олон улсын хамтын ажиллагааны бүс юм. Хятад Улсын Худалдааны яам, Гаалийн ерөнхий газраас хамтран 2008 онд ДГБ-ын тодорхойлолтод нэмэлт тайлбар гаргасан. Уг тайлбарт

“Чөлөөт худалдааны бүс гэдэг нь хоёр болон түүнээс дээш орон, эсхүл бие даасан гаалийн баталгаат бүс гэрээ байгуулах замаар үе шаттайгаар татварын болон татварын бус саад тотгорыг арилгах, хоёр улсын зах зээлийг улам нээлттэй болгох зорилгоор байгуулагдсан худалдаа болон хөрөнгө оруулалтын тусгай бүс юм.” гэжээ. ГАТТ-ийн хэлэлцээрээр ДХБ-ын улс орнууд чөлөөт худалдааны бүс байгуулахад тодорхой стандарт шаардлага, хязгаарлалт тогтоосон. Тухайлбал; чөлөөт худалдааны бүсийн худалдааны зарим хэсэг нь чөлөөтэй байх биш; харин бүхэлдээ чөлөөтэй байх шаардлага тавигддаг. Мөн гэрээний талуудыг заавал чөлөөт бүс дэх худалдаа, хөрөнгө оруулалт, үйлчилгээ, техник, оюуны өмч, байгаль орчин зэрэг асуудлаар харилцан тохиролцоонд хүрсэн байхыг шаардана.

ГАТТ-ийн III хэсэг, 24 дүгээр зүйлийн 4-т “Чөлөөт бүсийн зорилго нь бусад улсын бүрэлдэхүүн хэсэг болох газар нутагтай хийх худалдааг хөгжүүлэх явдал бөгөөд харин хэлэлцэн тохирогч бусад тал тухайн газар нутгийн хооронд хийх худалдаанд саад тотгор учруулах зорилгогүй”⁷ гэж тусгасан. Мөн уг хэлэлцээрийн 5-д уг хэлэлцээрт нэгдэн орсон улс орнууд болох хэлэлцэн тохирогч талууд дараах хоёр нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд чөлөөт

⁵ The World Bank, Special economic zones: Performance, lessons learned, and implications for zone development, 6 хуудас <https://documents1.worldbank.org/curated/en/343901468330977533/pdf/458690WP0Box331s0April200801PUBLIC1.pdf>

⁶ 陈晓芳 · 构建中日韩自由贸易区的国际法律问题浅析,

⁷ 1947, Тарифф, худалдааны ерөнхий хэлэлцээр, 24 дүгээр зүйл

худалдааны бүс байгуулах түр журам мөрдөх хэлэлцээр байгуулахад саад болохгүй гэж заасан.

Үүнд:

-түр хэлэлцээр байгуулахтай холбогдуулан ногдуулах татвар болон худалдааны бусад журам нь бүхэлдээ хэлэлцээр байгуулах үеэс илүү хязгаарласан шинжтэй бус байх, татварын хэмжээг илүү өндрөөр тогтоохгүй байх;

-хэлэлцээрийн гишүүн бус, эсхүл тухайн нутаг дэвсгэрт хамрагдахгүй хэлэлцэн тохирогч талын худалдаанд үйлчлэх хүчин төгөлдөр хураамж, худалдааны зохицуулалтын бусад журам нь чөлөөт худалдааны бүс байгуулах тухай түр хэлэлцээр байгуулахаас өмнө үйлчилж байсан холбогдох журамд зааснаас өндөр буюу илүү хязгаарлалт тогтоохгүй байх.

Дэлхийн хэмжээнд танигдсан чөлөөт худалдааны бүсээс дурдвал “NAFTA” буюу Хойд Америкийн чөлөөт худалдааны бүс, “CEFTA” буюу Төв Европын чөлөөт худалдааны бүс, “AFTA” буюу Зүүн Өмнөд Азийн чөлөөт худалдааны бүс юм. Эдгээр нь олон улсын түвшин дэх чөлөөт бүс тул “том чөлөөт худалдааны бүс” хэмээн нэрлэгддэг.

1.5 Жижиг чөлөөт худалдааны бүс буюу “FTZ”

Улс орнууд “FTZ” буюу жижиг чөлөөт худалдааны бүс байгуулахад дотоодын эрх зүйн зохицуулалтад голлон үндэслэдэг. Худалдааны чөлөөт бүсийн талаар ДХБ-аас гаргасан тодорхойлолт байхгүй бөгөөд харин ДГБ-аас батлагдсан Киотогийн хэлэлцээрт тодорхойлсон. Киотогийн хэлэлцээрт “Худалдааны чөлөөт бүс гэдэг нь нэгдэн орсон хэлэлцэн тохирогч улсын хилийн доторх тодорхой хил хязгаар бүхий онцгой бүс байх ба хилийн гаднаас уг бүсэд нэвтрэх бүх төрлийн бараа нь импортын гаалийн болон бусад татварын хувьд ихэвчлэн хилийн гаднах бараа гэж тооцогдож, гаалийн энгийн хяналтаас ангид онцгой дэглэм үйлчлэх бүсийг хэлнэ”⁸ гэж тодорхойлжээ. Чөлөөт худалдааны гэрээ (Free Trade Agreement) гэдэг нь хоёр ба түүнээс дээш орон худалдааг хөнгөвчлөх, эдийн засгийг глобалчлах зорилгоор байгуулсан хуулийн хүчин төгөлдөр олон улсын гэрээ юм. Өөрөөр хэлбэл; энэ бүсэд бүх бараа бүтээгдэхүүнийг гаалийн энгийн журмаар бус онцгой журмаар зохицуулж, гааль, татварын төрөл бүрийн хөнгөлөлт, чөлөөлөлт олгодог тусгай дэглэм бүхий бүс юм. Энэ төрлийн чөлөөт бүсийг “жижиг чөлөөт худалдааны бүс” гэж нэрлэдэг.⁹

Олон улсад “FTZ”-г ангилсан байдлыг судалж үзэхэд бүсийн зохион байгуулалт, үйл ажиллагааны төрөл, хүрээ, татвар, гаалийн горим, газар зүйн байрлал, онцлог зэргээс хамааран

⁸ WCO, Kyoto Convention


⁹ 郑淑珺, 我国自由贸易区的定位特点与立法体系完善, 北京师范大学, 北京 1000875

янз бүр байна. Чөлөөт худалдааны бүсийг үйл ажиллагааны хүрээ, горимоос хамааран олон янзаар нэрлэдэг бөгөөд эдгээр нь эдийн засгийн онцгой бүсийн нэг төрөл юм.

Эдийн засгийн чөлөөт бүс нь эдийн засгийн олон талт цогцолбор үйл ажиллагаа явуулж, түүнд тохирсон онцгой журам хэрэгждэг. Тухайлбал; эдийн засгийн чөлөөт бүсэд зөвхөн бараа бүтээгдэхүүнийг хадгалах, экспорт хийх зорилгоор үйлдвэрлэх, татваргүй барааны худалдаа эрхлээд зогсохгүй бүтээгдэхүүн боловсруулах, аялал жуулчлал, аж үйлдвэрийн парк, ногоон бүс зэрэг эдийн засгийн олон талт үйл ажиллагааг тусгай хөнгөлөлттэй бодлогын хүрээнд явуулах эдийн засгийн цогцолбор бүс юм.

Зураг 1. Эдийн засгийн чөлөөт бүсийн ялгаа

Эдийн засгийн онцгой бүс, чөлөөт бүсийн ялгаа



Эдийн засгийн чөлөөт бүсийн хөнгөлөлт нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад хамгийн чухал хүчин зүйл болдоггүй бөгөөд хөнгөлөлт, урамшууллын тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын баталгаа, дэд бүтцийн чанар, мэргэжилтэн, ажиллах хүч, засаг захиргааны хүнд суртлыг хялбаршуулах зэрэг нь голлох нөлөө үзүүлдэг.


ЗАМЫН-ҮҮД ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС

Чөлөөт бүс байгуулах нэг гол зорилго нь гадаадын хөрөнгө оруулалт татах явдал юм. Чөлөөт бүсийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийг судлан үзэхэд гадаадын хөрөнгө оруулагчид чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийх боломжит салбар болон тэдгээрт олгох татварын хөнгөлөлт чөлөөлөлт, урамшууллын зохицуулалт нь ЧБТХ-иас гадна салбарын хуулиар зохицуулагдаж байна. Хятад улс нь гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх, эсхүл хориглох салбарыг энэ маягаар жагсаалтаар баталдаг. Энэ нь хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад тус дөхөм болдог. Замын-үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нь Монгол, Хятад хоёр улсын хамтарсан бүс ба тус бүсэд хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчид хоёр улсын хөрөнгө оруулалтын орчинг харьцуулан Монголын талд, эсхүл Хятадын талд хөрөнгө оруулах эсэхээ шийднэ.

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлалыг 1995 онд баталж, 2002 онд “Чөлөөт бүсийн тухай”, “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай”, 2003 онд “Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай”, “Цагаануур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хуулиудыг батлан гаргасан байна.

Улмаар УИХ-ын 2004 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолоор “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж, нутаг дэвсгэрийн хэмжээг 900 га-гаар тогтоож, хилийн заагийг тодорхойлжээ.

Зураг 2. Замын-Үүд чөлөөт бүс



“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн зорилго:

“Олон Улсын жишигт нийцсэн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлснээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад” оршино.

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааны чиглэл нь


- Олон улсын ачаа тээвэр, тээвэр ложистик
- Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ
- Олон улсын аялал жуулчлал зэрэг юм.

“Замын-Үүд” чөлөөт бүс экспортын чиглэлтэй үйлдвэрлэл хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зэргээр эдийн засгийн хөгжлийг бий болох хамгийн тохиромжтой бүс юм.


Түүнчлэн хил орчмын худалдаа, мөн тэнд суурьшсан Монгол угсаатнуудын худалдааны харилцаа нь Монголын жижиг дунд үйлдвэрлэгчид, худалдаа эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж нээж өгөх тул чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн экспортын бүтээгдэхүүнүүдэд хангалттай эрэлт байна.

Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

Зураг 3. Замын-Үүд чөлөөт бүсийн тээвэр ложистикийн төлөвлөлт



Зураг 4. Замын-үүд чөлөөт бүсийн тээвэр, ложистикийн урсгалын байршил



Зураг 5. БНХАУ-ын Эрээн хот, МУ-ын Замын-үүд чөлөөт бүсийн төлөвлөлт



Зураг 6. БНХАУ-ын Эрээн хот чөлөөт бүсийн төлөвлөлт



“Монголын эдийн засгийн чуулган 2022” урьдчилсан хэлэлцүүлэгт “Боомтын сэргэлт” сэдвийн дор “Эдийн засгийн чөлөөт бүс хуурай боомтын хөгжлийн бодлогын асуудал” сэдэвт панель хэлэлцүүлэг явагдсан байна. Замын-Үүд чөлөөт бүсэд одоогийн байдлаар 88 аж ахуйн нэгж 113 га газрыг эзэмшдэг.

Замын-Үүд чөлөөт бүс 2021 оны наймдугаар сарын 14-нөөс байнгын үйл ажиллагаанд орсон. Өөрөөр хэлбэл, Монголын талаас иргэд орж үйлчлүүлэх боломжоор хангагдсан. Замын-Үүд чөлөөт бүсэд газар эзэмшдэг 88 аж ахуйн нэгжээс 3 дэлгүүр л байнгын үйл ажиллагаатай байгаа талаар мэдээлэл өгсөн байна.

Дээрх 88 ААН-ийн 41 хувь нь үйлдвэрлэлийн чиглэлээр, 34 хувь нь тээвэр ложистикийн чиглэлээр, үлдсэн хувь нь аялал жуулчлал, худалдааны чиглэлээр газар авсан.

Замын-Үүд чөлөөт бүс 2004 онд байгуулагдсан хэдий ч 2022 оныг хүртэл хугацаанд байнгын үйл ажиллагаанд ороогүй байна. Өнөөдрийн байдлаар уг чөлөөт бүсэд 3 дэлгүүр ажиллаж байгаа бөгөөд монгол талаас иргэд орж үйлчлүүлж байгаа нь хангалттай бус байна. Гэхдээ уг чөлөөт бүсийг бүрэн хэмжээнд ажиллагаанд оруулах талаар удирдлагын түвшинд

яригдаж байгаа нь сайшаалтай. Хэрэв уг чөлөөт бүс бүрэн ажиллагаанд орсон тохиолдолд дотоодын болон гадаадаас иргэд хүлээн авч худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл явагдах нөхцөл боломж тун удахгүй бүрдэхээр байна.

II БҮЛЭГ

2.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Монгол улсад чөлөөт бүс байгуулах тал дээр эрх зүйн байдлыг судлаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Чөлөөт бүсийн тухай хууль /2002 он/
2. Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн тухай эрх зүйн байдлын тухай хууль /2002 он/
3. Чөлөөт бүсийн тухай /Шинэчилсэн найруулга 2015 он/

УИХ-ЫН ТОГТООЛ

1. 1995 оны 87 дүгээр тогтоолоор “Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал” батлагдсан.
2. 1996 оны 66 дугаар тогтоолоор “Алтанбулаг” чөлөөт бүсийн хилийн заагийг тогтоосон.
3. 2002 оны 38 дугаар тогтоол “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт 500 га газарт “Алтанбулаг” чөлөөт бүс байгуулахаар тогтоосон.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1. 2011 оны 187 дугаар тогтоолоор “Замын-Үүд ”эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг баталсан.
2. 2014 оны 153 дугаар тогтоол “Бүсэд зорчигч, бараа, тээвэр түр нэвтрүүлэх журам”
3. 2015 оны 126 дугаар тогтоол “Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай”
4. 2018 оны 182 дугаар тогтоол “Газрын үнэлгээ тогтоох тухай”
5. 2019 - Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах хэлэлцээр байгуулсан
6. 2020 оны 104 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгө данснаас хасах, зөвшөөрөл олгох, бүртгэх тухай”
7. 2020 оны 105 дугаартай тогтоол “Чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалт”-ыг батлах тухай.

8. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай”

БУСАД ДҮРЭМ, ЖУРАМ

1. Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаал “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”
2. Гаалийн ерөнхий газрын даргын 2020 оны А/102 дугаар тушаал “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ын нэмэлт, өөрчлөлт
3. Улсын бүртгэлийн ерөнхий газар, “Алтанбулаг” чөлөөт бүс, “Замын-Үүд” чөлөөт бүс, “Цагааннуур” чөлөөт бүсүүдийн хамтарсан 2015 оны “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх тусгай журам”

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

УИХ, ЗГ-аас чөлөөт бүсийг хөгжүүлэх талаар дараах бодлогын баримт бичиг, хөтөлбөр батлагдсан байна.

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Уг бодлогын баримт бичгийн бүс нутгийн хамтын ажиллагаа хэсэгт “Гадаад худалдааны бодлогын хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж хөгжүүлэх, экспортын бараа бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн уялдуулсан тарифыг бий болгох, шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортлох таатай нөхцөлүүдийг урьдчилан бүрдүүлэх, үүний тулд тодорхой улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудалд онцгойлон анхаарах нь зүйтэй.” гэж дурдаад; бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчлөх зорилго тавьжээ. Энэхүү зорилгын хүрээнд:

1 дүгээр үе шат (2020-2030). Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, БНХАУ, ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе;

2 дугаар үе шат (2031-2040). Дэлхийн түвшинд нэр хүнд бүхий өрсөлдөх чадвартай Зүүн хойд Азийн хөрөнгө оруулалтын гол төв болгох зорилт тавьсан. Эдгээр зорилтын хүрээнд дараах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ гэж заасан:

-Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно;

-Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ;

-Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, тус бүсэд бага овортой, өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ;

-Улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна;

-Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх, худалдааг хөнгөвчлөх замаар урт хугацаанд өрсөлдөх чадвар бүхий цөөхөн салбарт эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх, экспортын боломж, зах зээлээ тэлэх бодлого явуулна;

-Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар худалдааг нэмэгдүүлнэ;

-АСЕАН-ийн хэлэлцээрт нэгдэн орж худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн интеграцад нэгдэх ажлыг эхлүүлнэ.

Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг УИХ-аас баталсан бөгөөд энэ хугацаанд гадаад худалдааг хөнгөвчлөх, нэмэгдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тодорхойлжээ:

1.Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчлөх зорилтын 4.4.1-д “Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай хэмжээний нөөцтэй, аж үйлдвэр хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон чөлөөт бүсийг хөгжүүлнэ”, 4.4.3-т “Эдийн засгийн коридорын хүрээнд “Талын зам” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийдвэрлэнэ”, 4.4.5-д “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, тус бүсэд бага овортой, өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ”;¹⁰

2.Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын 4.5.14-т “Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнасан худалдааны байнгын сүлжээг байгуулна”;

3.Бүс нутгийн эдийн засгийн интеграцид дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийн бүрдүүлэх зорилтын 8.1.6-д “Хөшигийн хөндий, Говьсүмбэрийн Баянталд эдийн засгийн чөлөөт бүс, карго логистикийн төв байгуулна”, 8.1.7-д “Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт бүсийг барьж дуусгана”;

4.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцаа зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх зорилтын 9.5.10-т “Улаанбаатар хотын бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрлэлүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна.

¹⁰ ЗГ-ын 2022.01.05-ны өдрийн ээлжит хуралдаанаар Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлыг хэлэлцээд, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов. Монгол Улсын Засгийн газрын цахим хуудас, <https://mongolia.gov.mn/news/view/26236>

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсыг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх таван жилийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг баталсан. Дунд хугацааны бодлогын баримт бичигт чөлөөт бүсийн талаар дараах зорилго, зорилтыг дэвшүүлжээ.

-Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евроазийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлнэ.

-Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.

-Гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ.

-Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, худалдааг хөнгөвчилнө.

-Экспортыг дэмжих, худалдааг хөнгөвчлөхөд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлагдсан. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн санхүү, төсвийн зохицуулалт хэсгийн 3.1.17-д “Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана”, 3.1.18-д “Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ.”; барилга, хот байгуулалт хэсгийн 3.7.14-т “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд оруулна”¹¹ гэж тусгасан.

Монгол Улсад Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал

УИХ-ын 1995 оны 87 дугаар тогтоолоор Монгол Улсад Чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал батлагдсан. Чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зорилгыг “тус улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт технологи оруулах замаар эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон. Энэхүү зорилгын хүрээнд “Чөлөөт бүсэд гадаадын

¹¹ Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийг 2021.08.14-ний өдөр байнгын ажиллагаанд оруулсан.

хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцөл бүрдүүлж, дотоодын аж ахуйн нэгжүүдийг тэдгээртэй эдийн засгийн ижил орчинд өрсөлдөх нөхцөлөөр хангах”; мөн угтвар нөхцөлд “Чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж, байгууллага чөлөөтэй, итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин нөхцөл бий болгох”, “гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц нөхцөл бүрдсэн байх” гэсэн арга хэмжээг авахаар заажээ.

“Талын зам” үндэсний хөтөлбөр

ЗГ-ын 2017 оны 142 дугаар тогтоолоор “Талын зам” үндэсний хөтөлбөрийг баталсан.¹² Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “Дэд бүтэц болон аялал жуулчлалын салбарын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, гадаад улс, тэр дундаа хөрш улсын дэд бүтцийн сүлжээтэй холбох, худалдаа, тээврийг хөнгөвчлөх, бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зардлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг хангах, төрөлжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлэх” юм. Хөтөлбөрийн хүрээнд чөлөөт бүсийн үйл ажиллагаанд дараах зорилтыг дэвшүүлсэн:

-Чөлөөт бүс, хилийн боомтуудад хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлж, хил орчмын бүс нутгуудыг хөгжүүлэн хот, суурин газруудыг шинээр байгуулна.

-Хилийн боомтуудыг орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах, хилийн хяналт, шалгалтыг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлж, бүртгэлийн үйл ажиллагаанд зарцуулагдаж байгаа хугацааг багасган, хяналт шалгалтын давхардлыг бууруулна. Эдгээр зорилтын хүрээнд “Алтанбулаг”, “Замын-Үүд” чөлөөт бүсийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлнэ гэжээ.

¹² “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт “эдийн засгийн коридорын хүрээнд “Талын зам” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН АКТЫН ТАЛААР:

Монгол Улс анх 2002 онд Чөлөөт бүсийн тухай бие даасан хуулийг батлан мөрдүүлж, 2015 онд шинэчлэн найруулсан. Уг хуулиар бусад улсын эдийн засгийн онцгой бүсийн хуультай адил чөлөөт бүсийн тодорхойлолт, чөлөөт бүс байгуулах зорилго, чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах харилцаа, чөлөөт бүсийн удирдлага, чөлөөт бүс дэх гааль, татвар, виз, мэргэжлийн хяналт, хуулийн этгээдийн бүртгэл, төлбөр тооцоо, хөдөлмөр эрхлэлтийн талаарх тусгай дэглэм, чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны төрөл, чөлөөт бүсийн газрын харилцаа, дэд бүтэц, харуул хамгаалалт зэрэг асуудлыг зохицуулдаг. Чөлөөт бүсийн үйл ажиллагаанд дээр дурдсан хуулиас гадна дараах журам, дүрмийг эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлж байна:

-Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журам;

-Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам;

-Чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зорчигчийн худалдаж авсан 3 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалт;

-Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, заавар, гэрээний загвар;

-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээ;

-Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам;

-Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам;

-Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам;

-Чөлөөт бүсэд эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох журам;

-Чөлөөт бүсэд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам.

-Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар дараах зарчмын өөрчлөлтүүд гарчээ. Үүнд:

-Чөлөөт бүсийг хэлбэрээр нь ангилсан заалтыг өөрчилж эдийн засгийн чөлөөт бүс гэдэг нэг л статустай болгосон, чөлөөт бүсийг хилийн боомт болон Засгийн газрын санал болгосон

Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс байгуулах урьдчилсан нөхцөл, боломж тусгай бүс нутагт байгуулж хөгжүүлэх, хил дамнасан чөлөөт бүсийн эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

- Чөлөөт бүсэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд үл харшлах, олон улсын гэрээний тулгуур зарчим, шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээ, худалдаа, олон улсын банк санхүү, даатгал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, нийгэм, зах зээл, дэд бүтцийн бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болохоор тусгасан.

- Чөлөөт бүсийн удирдлага, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг хуульчилж, Чөлөөт бүсийн Захирагчийн эрх хэмжээг нэмэгдүүлэв. Чөлөөт бүсэд бүртгэлийн, үйлчилгээний бүх байгууллага нэг дор төвлөрсөн, захиргаатай, захиргаа нь босоо удирдлагатай, бүх үйлчилгээг нэг цонхны үйлчилгээгээр шуурхай үзүүлэх боломжийг нээсэн.

- Татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах зэрэг үйл ажиллагааны тусгай дэглэмийг хуульчилж өгөв.

- Концессын гэрээний үндсэн дээр хувийн хэвшлийн хөрөнгөөр чөлөөт бүсийг бүхэлд нь буюу хэсэгчлэн байгуулж, хөгжүүлэх боломжтойгоор шинэчлэн тусгав.

- Чөлөөт бүсэд гадаад болон дотоодын иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмших, ашиглах зохицуулалтыг тодорхой болгов. Тухайлбал, чөлөөт бүсэд хөрөнгө оруулагч газрыг Монгол Улсын ямар хуулийн дагуу, хэдий хугацаанд, ямар төлбөртэй эзэмших, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлоход ямар хөнгөлөлт эдлэх зэрэг бүх зүйлийг хууль эрх зүйн талаас нь тодорхой болгосон байна.

Монгол Улсад 2002 онд баталсан Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан бөгөөд чөлөөт бүсийн төрлүүдийг нэг бүрчлэн хуульчилсан боловч үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо бүрдээгүй байсан тул 2015 онд тус хуулийг шинэчлэн найруулсан. уг хуулийн онцлог нь чөлөөт бүсийн төрөл хэлбэрийг нэг бүрээр нь тодорхойлоогүй боловч бүсэд явагдаж болох бүх үйл ажиллагааг хуульчилсан. Хуулийн зохицуулалт нь дэлхий нийтийн чиг хандлагатай нийцсэн, хөрөнгө оруулагчид, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа болон явуулах боломжтой хуулийн этгээдэд уян хатан нөхцлийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах болон үүнтэй холбоотой бусад асуудлыг шийдэх эрх зүйн орчин ерөнхий байдлаар бүрдсэн талаар судалгаанд дурьдсан байна¹³.

Дээрхээс үзэхэд Монгол улс нь чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах хууль, дүрэм, журмыг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулсан болох нь харагдаж байна. Харин чөлөөт бүсүүд өнөөдрийг хүртэл бүрэн ажиллагаанд ороогүй байгаа учраас зохицуулагдаагүй асуудал байсаар байна. Тодруулбал, чөлөөт бүс дэх төлбөр тооцоо, тээвэр ложистикийн асуудлыг зохицуулаагүй орхигдуулсан.

¹³ Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн судалгааны тойм, МУИС, 2017 он.

2.2 ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ТӨЛБӨР ТООЦООГ ГҮЙЦЭТГЭХ ТАЛААР

Олон улсын төлбөр тооцооны банкнаас төлбөрийн системийг төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх, үр дүнгийн тооцооллыг хийх эрх бүхий байгууллага, холбогдох дүрэм, журам, гэрээ болон төлбөрийн хэрэгслийн цогц нэгдэл гэж тодорхойлсон байдаг.

Төлбөр тооцооны системийн үндсэн зорилго нь банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Иймд төлбөрийн систем нь санхүүгийн системийн дэд бүтцийн чухал хэсэг төдийгүй мөнгөний бодлогыг дамжуулах гол суваг болж үйлчилдэг.

Чөлөөт бүсийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэнэ.”, 13.2 дахь хэсэгт “Чөлөөт бүсэд банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна” гэж,

Банкны тухай хуульд зааснаар Банк, түүний салбар байгуулах, гадаад улсад банк, банкны салбар байгуулахад Монгол банкны зөвшөөрөл авахаар зохицуулсан. Тодруулбал, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд /төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/, төрийн бус байгууллага, тэдгээртэй холбогдох этгээдээс бусад хуулийн этгээд, иргэн банк үүсгэн байгуулж болох бөгөөд энэ нь Засгийн газар банк үүсгэн байгуулахад хамаарахгүй.”, 18.2 дахь хэсэгт “Банк, түүний салбар байгуулах, гадаад улсад банк, банкны салбар байгуулахад Монгол банкны зөвшөөрөл авна.” гэж,

Төв банкны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэж, 2 дахь хэсэгт “Банк байгуулах, үйл ажиллагаа явуулах болон холбогдох бусад зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох,

банкны удирдлага, зохион байгуулалтын үндсэн зарчмыг тогтоох, хязгаарлалт хийх, шаардлага тавих, хяналт шалгалт хийх, банк, банкны нэгдэлд албадлагын арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.” гэж тус тус заасан.

Хуулийн дээрх заалтуудаас үзэхэд Монгол улс болон гадаад улсад банк, түүний салбарыг байгуулахад Монгол банкнаас зөвшөөрөл авах шаардлагатай талаар зохицуулсан байна.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд зааснаар уг хуулийн үйлчлэл хамаарах "Монгол Улсын нутаг дэвсгэр" гэж эдийн засгийн чөлөөт бүс, Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын байршлаас бусад Монгол Улсын газар нутгийг хэлнэ гэж тодорхойлсон.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А-81 тоот тушаалаар Гадаадын банкны хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 65.0 тэрбум төгрөгөөр буюу дотоодын банкуудад тавигдах 16.0 тэрбум төгрөгийн шаардлагаас 4 дахин ихээр тогтоосон байна. Гадаадын банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкны 2012 онд баталсан “Банкны зөвшөөрлийн журам”-д заасан шаардлагын дагуу олгох бөгөөд олон улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, өндөр зэрэглэлтэй, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй нэр хүнд бүхий байгууллагууд байх зэрэг шаардлагуудыг тусгасан.

Гадаадын хөрөнгө оруулалттай банк Монгол Улсад үйл ажиллагаа явуулснаар дараах давуу тал бий болно гэж судлаачид үзсэн байна¹⁴.

- Монгол улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана;
- Төв банкны хувьд бүрэн хяналт тавих боломжтой;
- Хуулийн этгээд байх учраас Монгол улсад орлогын албан татвар төлнө;
- Дотоодын банкуудтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулах, улмаар дотоодын зах зээлийн цар хүрээг өргөтгөж, өрсөлдөөнийг нэмэгдүүлж, эх үүсвэрийн хүүг бууруулах боломжтой;
- Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, технологийг нэвтрүүлэх замаар үр ашгийг дээшлүүлж, санхүүгийн дэд бүтцийг сайжруулах.

Хэдийгээр гадаадын банк, санхүүгийн байгууллагууд дотоодын зах зээлд нэвтэрч үйл ажиллагаагаа явуулснаар дээр дурдсан эерэг нөлөөллүүдийг үүсгэх боломжтой боловч энэ нь дотоодын банкуудын зах зээлийг эзлэх, тэдний өрсөлдөх чадвар, дархлааг сулруулах, багцын

¹⁴ Гадаадын хөрөнгө оруулалттай банк монгол улсад үйл ажиллагаа явуулахтай холбоотой үүсч болзошгүй эрсдэлүүдийн талаар, Судалгааны ажил, Товхимол-9, Монгол банк

эрсдэлийг нэмэгдүүлэх, олигопол болон монопол өрсөлдөөнийг дэмжих, гадаадын банк, санхүүгийн байгууллагын харьяа улсын эдийн засгийн мөчлөгөөс хамаарах хамаарлыг нэмэгдүүлэх гэх мэт сөрөг үр дагаврууд гардаг болохыг дүгнэсэн байна.

Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагуудын зүгээс гадаадын банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн тохиолдолд Монгол улсын санхүүгийн салбарын онцлог, үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор нөлөөлж болох бүхий л хүчин зүйлсийг харгалзан үзэж, бодитой нөлөөллүүдийг судалсны үндсэн дээр шийдвэр гаргах нь зүйтэй.


Иймд эдийн засгийн чөлөөт бүсэд дотоодын болон гадаадын банк, түүний салбарыг байгуулах, мөнгөн төлбөрийн гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгт болон валютаар гүйцэтгэх боломж нээлттэй байж болох юм. Харин гадаад валютаар гүйлгээ хийх тохиолдолд уг гүйлгээний дүнгийн тодорхой хувийг заавал үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх талаар зохицуулалт байх нь зүйтэй. Гэхдээ уг харилцааг тухайн чөлөөт бүсэд хэрхэн зохицуулах, нутаг дэвсгэрийн болон бусад нөхцөлийг нарийвчлан зохицуулсан хэм хэмжээний акт байхгүй байна. Өөрөөр хэлбэл, хуулиар ерөнхийд нь зохицуулсан асуудлыг нэг мөр хэрэглэх, хуулийн хийдэл, давхардал зэрэг асуудал үүсгэхгүйн тулд уг харилцааг зохицуулсан хэм хэмжээний актыг гаргах нь зүйтэй. Уг асуудал нэг мөр болсноор мөнгөн тэмдэгт хоорондын бэлэн болон бэлэн бус гүйлгээг гүйцэтгэх боломж бүрдэнэ. Учир нь чөлөөт бүсэд дотоодын болон гадаадын иргэд, хуулийн этгээд худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл зэрэг үйл ажиллагааг эрхлэх бөгөөд улс хоорондын мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийхэд худалдаанд оролцож буй талуудын дунд маргаан үүсэх зэрэг эрсдэл үүсэхгүй. Мөн иргэд, хуулийн этгээдийн хоорондын мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлд илүү хялбар болно.

2.3. ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улс нь 1.56 сая хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй, урд талаараа БНХАУ-тай 4.677 км, хойд талаараа ОХУ-тай 3543 км урттай тус тус хиллэдэг далайд гарцгүй эх газрын эрс тэс уур амьсгалтай орон боловч зам тээврийн сүлжээ, газар зүйн байрлалын хувьд Зүүн хойд Азийн бус нутагт хүн ам олонтой, өргөн уудам газар нутагтай, хүчирхэг эдийн засаг, байгалийн асар их нөөц баялаг, багтаамж бүхий зах зээлтэй, дэлхийн томоохон гүрнүүд болох ОХУ, БНХАУ-ын хооронд оршдог.

Далайд гарцгүй Монгол орны хувьд автотээврийн салбарын гадаад зах зээлийг хөгжүүлэх, өсөн нэмэгдэж буй тээврийн эрэлт хэрэгцээг хангахын тулд олон улсын болон бүс нутгийн тээвэр, логистикийн сүлжээгээр дамжуулан гадаад худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын чанартай хуурай боомтуудыг байгуулах, олон улсын гэрээ конвенцид нэгдэн орох замаар автотээврийн салбарыг нээлттэй хөгжүүлэх хэрэгцээ бий болж байна.

Зураг 7. МУ-ын тээврийн тогтолцоо



Хүснэгт 3. Тээврийн салбарын бүтээгдэхүүн /ачаа тээвэрлэлт/

Тээврийн төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Тээсэн ачаа, мян.тн							
Авто замын тээвэр	25635.3	32898.9	21321.9	23514.2	16682.2	20406.2	31200.0
Төмөр замын тээвэр	18447.7	20445.2	21035.5	21118.6	19150.8	19989.1	22765
Агаарын тээвэр	2.9	4.0	4.1	3.4	2.8	3.1	3.1
Усан замын тээвэр	-	-	-	-	-	-	-
Нийт	44086.0	50644.3	42361.4	44636.2	35838.8	40398.4	53918.1
Ачаа эргэлт сая тн.км							
Авто замын тээвэр	4910.3	3503.9	2555.8	4936.4	3139.9	3997.7	5661.3
Төмөр замын тээвэр	11418.7	12142.7	12076.5	12473.7	11462.6	12371.0	13493.3
Агаарын тээвэр	7.7	9.7	9.6	9.4	7.7	8.1	7.8
Усан замын тээвэр	-	-	-	-	-	-	-
Нийт	16336.7	15656.4	14641.9	17419.5	14610.2	16376.8	19162.4

Тээврийн салбарын гүйцэтгэлээс харахад 2017 оны жилийн эцсийн байдлаар 56.9 сая тонн ачаа, давхардсан тоогоор 215.8 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад тээсэн ачаа 13.5 сая тонн буюу 23.7 хувиар өссөн, зорчигчийн тоо 67 сая хүн буюу 31 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тээврийн төрлүүдээр гүйцэтгэсэн ачаа, зорчигч тээврийн гүйцэтгэлээс харахад улсын хэмжээний ачаа тээврийн 65 гаруй хувийг, зорчигч тээврийн 98,7 хувийг автотээврээр гүйцэтгэж байна¹⁵.

¹⁵ Зам тээвэр, логистикийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгаа. 2018 он

Автотээврийн тухай хуулийн 8.2-т “Улс хоорондын тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг олон улсын тээврийн харилцааны гэрээг үндэслэн автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах бөгөөд түүнийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ”, 8.3-т “Хот хоорондын ачаа, ... тээвэрлэлтийн чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох аймгийн Засаг даргатай хамтран гаргаж хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулж байгаа боловч хот хоорондын ачаа тээврийн үйл ажиллагаанд ямар нэгэн зохицуулалт хийгдээгүй.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 201 дүгээр тушаалаар Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийг баталж, тээвэрлэгчид тавигдах шаардлага, ачаа тээвэрлэлтийн гэрээний гол нөхцөл, тээвэрлэлтийн даатгалын асуудлыг зохицуулсан боловч өнөөдрийн байдлаар улс хоорондын ачаа тээвэрлэлтээс бусад дотоодын ачаа тээврийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих ажил учир дутагдалтай байна.

Автотээврийн тухай хуулийн дагуу автотээврийн салбарын хөгжлийн бодлогыг Зам тээврийн хөгжлийн яамнаас тодорхойлж, тээвэр зохион байгуулалт, зохицуулалтыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ улсын хэмжээнд хариуцан гүйцэтгэдэг.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар Автотээврийн тухай хуульд заасан төрийн захиргааны төв байгууллагын зарим чиг үүргийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж байна.

“Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-т шилжүүлэн гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд улс, хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлт, жуулчин, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах, автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах, мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох, авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг аймаг, орон нутагт зохион байгуулах зэрэг нь болно.

Автоээврийн дэд бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Автотээврийн тухай хуульд тодорхой зохицуулалтгүй байна. Энэхүү асуудлыг Автотээврийн тухай хуульд тусган зохицуулах хэрэгцээ шаардлага нийгэм, эдийн засгийн хөгжлийн дагуу зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалтын үндсийг хуулиар бий болгох нь тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ бүрдүүлэх, улмаар олон улсын тээвэрлэлт, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй байна.

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичиг эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр,

ложистикийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр эхний ээлжинд Замын-Үүд, Хөшигтийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж,... дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх, хоёр, гуравдугаар үе шатанд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхайн салбарт түшиглэсэн тээвэр ложистикийн шинэ төвүүдийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ, Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ гэж тусгажээ.

Монгол Улсын логистикийн үйлдвэрлэлийн хэмжээ болон өнөөгийн байдал

➤ Логистикийн үйлдвэрлэлийн хэмжээ: Монголын агуулах, тээврийн салбарын хэмжээ нь 2019 оны байдлаар 1683.6 тэрбум төгрөг, өмнөх жилээс 3.2 хувиар өссөн, 2015 оноос хойш 5 жилийн турш байнгын өсөлттэй байна.

➤ Үйлдвэрлэлд оруулах хувь нэмэр: Тээврийн салбарын үр ашиг дээшилж байгаа. Гэвч ДНБ өсөлт дэх тээврийн салбарын хувийг харвал 2019 онд 4.5% бөгөөд 2015 оны 5.2%-ийн өсөлттэй харьцуулахад буурч байгаа хандлагатай байна.

➤ Компанийн бүтэц: 2020 оны I улирлын байдлаар тээвэр логистиктой холбоотой 1694 компани бүртгэгдсэн байна. Энэ нь зам тээврийн салбарын нийт компанийн 77 хувийг эзэлж байна. Харин агуулахын салбар 20 хувийг эзэлж, хамтдаа зам тээвэр агуулахын салбарын 97 хувийг бүрдүүлж байна.

➤ Агуулахын салбар: Агуулахын салбарын хувьд ихэнх нь тогтмол дулаантай агуулах байна. Хүнсний бүтээгдэхүүнийг шинээр нь хадгалах, түгээхийн тулд хөлдөөх, хөргөөх агуулахын дэд бүтэц хомс тул энэ салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэж таамагласан байна¹⁶.

Хүснэгт 4. Логистикийн салбарын өнөөгийн байдал

Ангилал	2015	2016	2017	2018	2019
Нийт ДНБ	231,503.8	239,428.6	278,762.9	324,112.2	368,976.4
Тээврийн салбарын хэмжээ	12,105.9	12,394.4	13,703.7	15,166.8	16,836.7

¹⁶ Монгол улсад ухаалаг логистик, тээврийн хөгжүүлэх стратеги, 2021 он

ДНБ өсөлтийн хувь	2.4	1.2	5.3	7.2	5.1
Тээврийн салбарын өсөлтийн хэмжээ	5.1	11.5	14.2	7.6	3.2

Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан дээрх зорилгод хүрэх, өсөн нэмэгдэж буй тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг хангах, Монголын тээвэрчдийг бүс нутгийн болон олон улсын зах зээлд гаргах, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үндэсний тээвэр логистикийн сүлжээг бүрдүүлэх, үүгээр дамжин олон улсын тээвэр логистикийн сүлжээнд нэгдэх боломж нөхцлийг бүрдүүлэх нь тээврийн салбарын өнөөгийн тулгамдсан асуудал болсоор байгааг судалгаагаар тогтоосон байна¹⁷. Иймд дотоодын тээврийг хөгжүүлэх арга замуудыг тодорхойлж, хэрэгжүүлж, төрөөс “логистикийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг боловсруулан батлуулах шаардлагатай.

Учир нь аливаа улс орны хөгжилд бараа бүтээгдэхүүний тасралтгүй хөдөлгөөн амин чухал үүрэгтэй. Тээвэргүйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоо явагдахгүй тул улс орны эдийн засгийн хөгжил дэвшлийг цогцлооход найдвартай, бүтээмж сайтай тээвэрлэлт шаардлагатай. Логистик хэмээх концепцид тээвэрлэлт, түгээлт, хадгалалт, ачилт буулгалт болон үйлдвэрлэл ба хэрэглээг дэмжих мэдээлэл, мөнгөний урсгал зэргийг багтаан ойлгодог. Эдийн засаг өсөн тэлэхэд логистикийн өндөр бүтээмжтэй тогтолцоо зайлшгүй чухал.

“Замын-Үүд” чөлөөт бүс нь Ази-Европыг холбосон хуурай замын гол зангилаа, олон улсын тээвэр логистикийн төв болох бүрэн боломжтой учраас нийгэм, эдийн засгийн хувьд өргөн хүрээнд харж, ирээдүйн үр өгөөжийг тооцон, алсын хараатай бодлого, төлөвлөлтийн дагуу үйл ажиллагааг нь явуулах ёстой. Монгол Улсын логистикийн талаар баримтлах төрийн бодлого, эрх зүйн орчин, нэгдсэн зохицуулалт, эдгээрийг хариуцан гүйцэтгэх институциональ нэгжийн асуудал орхигдсон.

Чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд оруулснаар, гүний гарцаар зорчигч, ачаа тээврийн хэрэгсэл нэвтэрч эхэлнэ. Цаашид үйлдвэрлэл, тээвэр, логистик, аялал жуулчлал, бизнесийн чиглэлүүд түлхүү хөгжинө.

¹⁷ Зам тээвэр, логистикийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгаа, 2018 он

Явцын дүгнэлт:

Монгол Улсын урт болон дунд хугацааны гурван бодлогын баримт бичиг, хоёр үзэл баримтлал, хөтөлбөрт гадаад худалдааг хөгжүүлэх, чөлөөт бүс байгуулах зорилго, зорилгод тодорхой, хангалттай тусгагдсан байх бөгөөд зорилго, зорилтууд нь хоорондоо нийцсэн, уялдаатай байна. Ерөнхий зорилго нь чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд оруулах, хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх зэрэг байх боловч хэтэрхий ерөнхий байдлаар заагдсан.

Чөлөөт бүсийн тухай хууль нь ерөнхий асуудлыг зохицуулах шинжтэй байх бөгөөд уг хуулийг боловсронгуй болгосноор түүнийг даган хэм хэмжээний актууд гарах нөхцөл бүрдэнэ. Өнөөдрийн байдлаар чөлөөт бүсийн үйл ажиллагааг зохицуулах 10 гаруй хэм хэмжээний акт гарсан боловч чөлөөт бүсэд гүйцэтгэх төлбөр, тооцоо болон тээвэр ложистикийн асуудлыг зохицуулсан хэм хэмжээний акт байхгүй байна.

Манай улсад чөлөөт бүсийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг батлагдсан, урт хугацаандаа хэрэгжих боловч нарийвчилсан зохицуулалт дутмаг байна. Чөлөөт бүсэд аль улсын банкныг байгуулах, төлбөр тооцоог хэрхэн гүйцэтгэх зэрэг асуудлыг боловсронгуй болгох нь зүйтэй.

Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн судалгааны судлаачид Чөлөөт бүсийн тухай хуулийг судлаад Валютын зохицуулалтын тусгай дэглэмийг хуульд нарийвчлан тодорхойлж өгөх, өөрөөр хэлбэл, тухайн бүсэд мөнгөн гүйлгээ хийхэд ашиглах гадаад валют, төлбөр тооцооны зохицуулалтыг бий болгож, чөлөөт бүсэд шилэн кабель, интернетийг тавьснаар барааны бүртгэлийг цахим хэлбэрээр хийх боломж бүрдэх юм. Төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэх талаар бусад эрх зүйн хэм хэмжээний актыг боловсруулж гаргах хэрэгтэй байна. Тухайлбал, Монгол банкнаас тодорхой журам гаргах шаардлагатай гэсэн зөвлөмжийг 2017 онд гаргаж байжээ.

Уг асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна. Чөлөөт бүс бүрэн ажиллаж эхлэхээс өмнө төлбөр тооцооны асуудлыг нэг мөр болгох нь зүйтэй.

Дэлхийн банкны хил дамнасан худалдааны үзүүлэлтээр Монгол Улсын хууль тогтоомж, хилийн хяналт болон авто зам, төмөр замын дэд бүтэц буюу тээвэр ложистикийн бүтцийн хөгжил

сул, гааль, мэргэжлийн хяналт, гадаад худалдааны бусад хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хүнд суртал голлох нөлөө үзүүлсэн гэж дүгнэсэн байна.

Чөлөөт бүсэд логистикийн нэгдсэн төв байгуулснаар чингэлгийг ачиж буулгах давтамж цөөрөхөөс гадна нийт үйл ажиллагааны бүтээмж сайжирч, сул зогсолтыг бууруулах тул тээвэр, логистикийн дэд бүтцийн хүчин чадлын ашиглалт нэмэгдэнэ. Ачаа тээврийн урсгалыг нэг цэгт төвлөрүүлэх нь чингэлгийн ашиглалтыг сайжруулж, цуглуулбар ачааг цөөлөх ач холбогдолтой.

Түүнчлэн, логистикийн салбарын тухай суурь хууль, логистикийн салбарыг сайжруулах, логистикийн үйлчилгээг өндөр түвшинд хүргэх, логистикийн байгууламжийг барихтай холбоотой тусдаа хууль байхгүй байна. Тээврийн хэлбэр тус бүрээр дэд бүтцийг бүтээн байгуулах болон үйлчилгээг удирдахад төвлөрсөн хууль байгаа тул логистикийн салбарыг сайжруулах болон байгууламжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хууль гаргах шаардлагатай.

2.4. ХАРЬЦУУЛАЛТ /БНХАУ-ЫН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ

ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, АНГИЛАЛ/

Хятад улс анх 1978 оноос шинэчлэл өөрчлөлтийн замд орж, дотоодын зах зээлээ гадаад зах зээлд нээлттэй болгож эхэлсэн. Хятад улс 2001 онд ДХБ-д элссэнээр дэлхийн эдийн засгийг глобалчлах үйл явцад идэвхтэй оролцох болсон. ДХБ-д элссэн цагаас эхлэн Хятад улс олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа бүрэн биелүүлж, дэлхийн эдийн засгийн гол тоглогч нарын нэг болсон юм.

Хятад улс ДХБ-ын өмнө хүлээсэн барааны худалдааг хөнгөвчлөх амлалтын хүрээнд импортын барааны татварыг их хэмжээгээр бууруулж, 2001 онд дунджаар 15.3 хувь байсныг 9.8 хувь болгосон. Үйлчилгээний салбарын хувьд ДХБ-ын гаргасан 12 нэр төрлийн 160 салбараас 9 төрлийн 100 салбарыг гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй болгох үүрэг амлалт өгсөн. Энэ амлалтаа 2007 онд биелүүлсэн байна. Хятад улс мөн оюуны өмчийг хамгаалах чиглэлээр анхаарлаа хандуулан ажиллах санаачилга гарган амлалт өгсөн. Энэ хүрээнд олон улсын шилдэг туршлагаас судлан, ДХБ-ын холбогдох дүрэм, журамд нийцсэн оюуны өмчийн эрх зүйн тогтолцоог бий болгосон. Тухайлбал Хятад улс Барааны тэмдэгийн тухай хууль, Шударга өрсөлдөөний тухай хууль, 2020 онд Патентын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хуулийг боловсруулан баталжээ. Мөн Бээжин, Шанхай, Гуанжоу хотод оюуны өмчийн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий дагнасан шүүх байгуулсан.

Хятад улс ДХБ-аас баталсан “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр” хэрэгжих нэг жилийн хугацаанд худалдааг хөнгөвчлөх шат дараатай арга хэмжээ авч, гаалийн бүсэд нэвтрэх хугацааг 20 цаг, гаалийн хилээс гарах хугацааг 2 цаг орчим болгож бууруулсан. Мөн нэг цонхны үйлчилгээг нэмэгдүүлж, одоогийн байдлаар 28 муж нэг цонхны үйлчилгээ үзүүлж байна.

Хятадын чөлөөт бүсийн тухай ойлголт нь 20 орчим жилийн өмнө Шанхай хотод байгуулагдсан баталгаат бүсээс эхлэлтэй. Тухайн үед уг баталгаат бүсийг “bonded area” бус FTZ буюу чөлөөт худалдааны бүс хэмээн нэрлэсэн. Энэ нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн FTZ-ээс арай өөр ойлголт байсан юм. Олон улсад FTZ-г хилийн дотор байгаа чөлөөт бүсийг хилийн гадна бүс хэмээн тооцох, тухайн бүс дэх бараа бүтээгдэхүүнийг татвараас хөнгөлж, чөлөөлөх бодлого хэрэгжүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжиж, хөрөнгийн урсгалыг дотоодын зах зээл рүү чиглүүлэх арга хэмжээ хэмээн ойлгож байсан. Харин тухайн үед Хятадад байгуулагдсан чөлөөт худалдааны бүс нь хилийн дотор байгаа чөлөөт бүсийг хилийн дотор байгаа бүс хэмээн тооцож, гаалийн

бүрдүүлэлт, хяналт шалгалтыг хэрэгжүүлж, бүрэн хэмжээгээр чөлөөтэй худалдаа эрхлэх боломж олгоогүй юм. Иймд тухайн үед байгуулагдсан чөлөөт бүс одоогийн байгуулагдсан чөлөөт бүстэй адилгүй болно. Хятад улсын хувьд чөлөөт бүсийг жинхэнэ утгаар нь анх 2013 онд Шанхай хотод байгуулж, ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх журмыг батлан мөрдүүлсэн. Энэхүү ерөнхий төлөвлөгөөгөөр чөлөөт бүсийг хилийн доторх, гаалийн хяналтын бүс хэмээх бодлогыг хэрэгжүүлж, “нэг дэх шугам нээлттэй, хоёр дахь шугам өндөр хяналттай, бүс дотор урсгал чөлөөтэй” байх гаалийн хяналт шалгалтын зарчмыг хэрэгжүүлсэн.

Гаалийн хяналт шалгалтын зарчмыг дараах утгаар тайлбарласан:

-Нэг дэх шугам нээлттэй гэдэг нь чөлөөт бүсийн хилээр нэвтэрч, гарч буй бараанд сөрөг жагсаалтын аргаар хяналт тавих ба уг жагсаалтад хамаарахгүй бараа бүтээгдэхүүн уг бүсэд чөлөөтэй нэвтрэх, гарах эрхтэй. Аливаа тоо хэмжээ, арга хэлбэр, татвар, гарал үүсэл, бараа ачигдсан газар болон тээвэр хийсэн улсын аливаа нөхцөл шаардлагын хязгаарлалтад хамаарахгүй. Мөн бараа чөлөөт бүсийн хилээр нэвтрэх, гарах процессыг хамгийн дээд хүчин чадлаар бууруулдаг. Тухайлбал бараа ачсан усан онгоц боомтын хилээр нэвтрэх, эсхүл гарах үед зөвхөн манифест бөглөх ба чөлөөт бүс дотор бараа буулгах, ачих, хадгалахад гаалийн хяналтаас хараат бус байна.

-Хоёр дахь шугам өндөр хяналттай гэдэг нь чөлөөт бүс болон улсын хилийн доторх бусад бүсийн хооронд бараа бүтээгдэхүүн нэвтрэх, гарахад гаалийн онцгой журмаар бус энгийн журмын дагуу хяналт хэрэгжүүлэхийг ойлгоно. Өөрөөр хэлбэл; бараа бүтээгдэхүүн хилээр нэвтрэх, гарахад заавал гаалийн мэдүүлэг бөглөж энгийн журмын дагуу бүрдүүлэлт хийнэ. Мөн чөлөөт бүсээс дотоодын аль нэг боомтоор дамжин хилийн гаднах аль нэг боомт руу тээвэрлэх тохиолдолд мөн гаалийн энгийн журмаар хяналт тавина.

-Бүс дотор чөлөөтэй гэдэг нь чөлөөт бүсийн хилийн доторх бараа бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх, хадгалах, боловсруулах, худалдахад чөлөөтэй байхыг ойлгодог.

Чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө

Орон нутагт чөлөөт бүс байгуулахад орон нутгийн засаг захиргааны нэгжээс Төв ЗГ-т санал хүргүүлэх ба Төв ЗГ чөлөөт бүс байгуулах боломжтой гэж үзвэл байгуулах, хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг ЗГ, түүнийг төлөөлөн Худалдааны яам, орон нутгийн удирдлага хамтран¹⁸ тухай бүр баталдаг. Энэхүү төлөвлөгөө нь чөлөөт худалдааны бүс байгуулах зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, худалдааг өргөжүүлэх, нээлттэй болгох, гадаадын хөрөнгө оруулалтын тогтолцоог шинэчлэх гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрддэг. Энэхүү ерөнхий төлөвлөгөөнд орон нутгийн удирдлагаас зохицуулах харилцааны хүрээг тодорхойлсон. Эдгээр төлөвлөгөөний бүтэц, агуулга

¹⁸ 中国自由贸易区立法体系 ·

нь ерөнхий шинжтэй бөгөөд ихэвчлэн бодлогын шинжтэй заалт тусгагдсан. Холбогдох асуудлыг нарийвчлан зохицуулах процессын шинжтэй заалт дутмаг байдаг.

Хятад улсын 14 дэх таван жилийн төлөвлөгөө

Хятад улс нь улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөг таван жил тутамд батлан хэрэгжүүлдэг бөгөөд 2021 оны 03 сарын 12-ны өдөр 14 дэх таван жилийн төлөвлөгөө буюу “145” гэсэн төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөний 3 дахь хэсэгт Худалдааны чөлөөт бүс байгуулах ажлыг түргэтгэж, дэлхийн стандартад нийцсэн чөлөөт худалдааны бүсийн сүлжээг байгуулна. Чөлөөт худалдааны бүсийн зохион байгуулалтыг оновчтой болгож, өндөр түвшний чөлөөт худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурахыг дэмжих, Номхон Далай дамнасан түншлэлийн иж бүрэн, дэвшилтэт хэлэлцээрт анхаарч, Хятад, Япон, Солонгосын чөлөөт худалдааны хэлэлцээрийг хурдасгах, Ази, Номхон далайн чөлөөт худалдааны бүсийн бүтээн байгуулалтыг тууштай ахиулж, Норвеги, Өмнөд Солонгос (II үе шат), Сингапур (шинэчлэлтийг дагаж мөрдөх), Израиль, Перу (шинэчлэл), Шри Ланка, Палестин, Молдав, Беларусь болон бусад улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрийг шинэ шатанд ахиулна гэж заажээ. Мөн чөлөөт худалдааны бүс байгуулах түвшин, бараа бүтээгдэхүүний худалдааг либералчлах түвшин, үйлчилгээний салбар дахь хөрөнгө оруулалтын сөрөг жагсаалтын аргыг нэмэгдүүлэх, чөлөөт худалдааны хэлэлцээрийн үр дүнг ашиглан бүс нутгийн эдийн засгийн түншлэлийн иж бүрэн хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, аж ахуйн нэгжүүдэд холбогдох хөнгөлөлттэй бодлогыг зохистой ашиглахад туслах зорилт тавин ажиллана гэжээ.

Хятад Улсын эдийн засгийн онцгой бүсийн хууль тогтоомжийн зохицуулах хүрээ, агуулга

Хятад Улсад эдийн засгийн онцгой бүсэд хэрэгжих ерөнхий төлөвлөгөө, журам, дүрмийг тухайн орон нутгийн удирдлага Засгийн газраас эрх олгосны үндсэн дээр батлан хэрэгжүүлэх ба бүсийн зорилго, онцлогт тохирсон харилцан адилгүй зохицуулалттай байна.

Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийн хууль тогтоомжийн агуулга, зохицуулалтыг дурдая. Шанхай хотын Ардын төлөөлөгчдийн байнгын хорооны 14 дүгээр хурлаар Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийн ерөнхий төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөө нь дараах асуудлыг зохицуулсан 6 бүлэгтэй болно:

- Бүсийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт;
- Хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх;
- Худалдааг хөнгөвчлөх;

- Санхүүгийн үйлчилгээ;
- Татварын хөнгөвчилсөн зохицуулалт;
- Ерөнхий хяналт.

Шанхай хотын Ардын Засгийн газрын 2013 оны 7 дугаар тогтоолоор Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийн үйл ажиллагааг зохицуулах журмыг баталсан. Энэхүү журмаар туршилтын бүсийн дараах асуудлыг зохицуулдаг: ¹⁹

Хүснэгт 5. Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийн журмын бүтэц

Журмын дүгээр бүлэг	1	Чөлөөт худалдааны туршилтын бүсийн зорилго, журмын зохицуулах хүрээ, бүсийн чиг үүрэг
Журмын дугаар бүлэг	2	Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн байгууллага, түүний чиг үүрэг, нэгдсэн үйлчилгээний төв, бүсэд үйл ажиллагаа явуулах төрийн байгууллага, бусад байгууллага
Журмын дугаар бүлэг	3	Хөрөнгө оруулалтын салбар, хөрөнгө оруулалтын зохицуулалтын тогтолцоо, бүсийн дотор үйл ажиллагаа эрхлэгч хилийн чанадад оруулсан хөрөнгө бүртгэлийн тогтолцоо
Журмын дүгээр бүлэг	4	Далайн худалдаа, далайн тээвэр, далайн тээврийн бүртгэлийн журам, хилээр нэвтрэх, гарах хяналтын тогтолцоо, хорио цээр, хилээр нэвтрэх, гарах үйлчилгээг хөнгөвчлөх
Журмын дугаар бүлэг	5	Санхүүгийн тогтолцооны шинэчлэл, валют арилжаа, Хятадын мөнгөн тэмдэгтийн хэрэглээ, валютын удирдлага, санхүүгийн эрсдэлээс хамгаалах
Журмын дугаар бүлэг	6	Бүсийн нэгдсэн удирдлага, үйлчилгээ, мэдээллийн ил тод байдал, нэг цонхны үйлчилгээ, аюулгүйн хяналт шалгалт, зах зээлийн монополын эсрэг хяналт шалгалт, оюуны өмчийн хамгаалал, үйл ажиллагааны тайлангийн тогтолцоо, ерөнхий үнэлгээ, дүгнэлтийн тогтолцоо, маргаан хянан шийдвэрлэх
Журмын дугаар бүлэг	7	Бусад асуудал

Улсын хэмжээнд болон орон нутгийн түвшинд хэрэгжих дараах журам, тогтоолыг батлан хэрэгжүүлж байна:²⁰

- Чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчийг бүртгэх журам;

¹⁹ <https://www.zjsfq.gov.cn/>

²⁰ <https://www.zjsfq.gov.cn/>

-Чөлөөт бүсийн гадаадын хөрөнгө оруулалтын сөрөг жагсаалт (Хятадын Хөгжил, шинэтгэлийн хорооны 2020 оны 33 дугаар тогтоол);

-Гадаадын хөрөнгө оруулалтын сөрөг жагсаалт (Хятадын хөгжил шинэтгэлийн хороо, худалдааны яамны 2020 оны 32 дугаар хамтарсан тогтоол);

-Чөлөөт бүсэд гадаадын хөрөнгө оруулалт нэвтрэх аюулгүй байдлыг хянан шалгах журам (Худалдааны яамны 2020 оны 37 дугаар тогтоол);

-Мужийн хуулийн этгээдийн бүртгэлийн журам;

-Бүсэд хүний нөөцийг хөгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан журам;

-Бүсэд иргэн, тээврийн хэрэгсэл нэвтрэх, гарах журам;

-Бүсэд нээлтийн бодлого турших журам;

-Бүсэд инноваци бүхий шинэ бизнес эрхлэхийг дэмжих журам;

-Бүсэд оюуны өмчийг хамгаалах журам;

-Бүсийн газар ашиглалтын эрхийг дуудлага худалдаагаар шилжүүлэх журам;

-Хөрөнгө оруулалтын сөрөг жагсаалт;

-Бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх журам;

-Цахилгаан, эрчим хүчний хэрэглээний орчинг сайжруулах журам;

-Улсын 14 дүгээр таван жилийн төлөвлөгөөг бүсэд хэрэгжүүлэх төлөвлөгөө;

-Бүсийн экологи, байгаль хамгаалах журам;

-Усны нөөцийг хамгаалах, ашиглах журам;

-Цахим гэрчилгээ олгох, ашиглах журам;

-Хорио цээрийн хяналтын журам;

-Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн эрсдэлийн хохирлыг нөхөн төлөх журам;

-Бүсэд үйл ажиллагаанаас олсон орлогыг хянах ажлыг хөнгөвчлөх журам;

-Хятадын мөнгөн тэмдэгтийн зээлийн харилцааг зохицуулах түр журам;

-Бүсэд бараа, бүтээгдэхүүн нэвтрэх, гарах хорио цээрийн хяналтын журам;

-Гаалийн баталгаат бүс дэх бараа тээвэрлэлтийн журам;

-Бүсийн хил дамнасан цахим худалдааны хорио цээрийн хяналт хэрэгжүүлэх дүрэм;

-Гаалийн хяналтын журам зэрэг болно.

Хятад Улсын чөлөөт худалдааны бүсийн бодлого, төлөвлөгөө, зохицуулалт (“FTA”, “FTZ”)

Том чөлөөт худалдааны бүс (FTA)

Хятад Улс нь эдийн засгийн олон талт тогтолцоог бий болгохыг зорьж, ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ БҮС байгуулах бодлогыг дэмжиж байна. Тухайлбал; Хятад улсын чөлөөт худалдааны гэрээтэй гадаад улстай хийсэн худалдаа нь тус улсын нийт гадаад худалдааны 25.9 хувийг эзэлнэ. Нийт байгуулагдсан гэрээнд татвараас бүрэн чөлөөлөгдсөн бараа бүтээгдэхүүний эзлэх хэмжээ 90 хувиас давж, ДХБ-д элсэх үед хөрөнгө оруулалтын нээлттэй 100 салбар байсныг 120 болгон нэмэгдүүлж, гадаад зах зээлд илүү нээлттэй болсон.

Хятад Улс том чөлөөт худалдааны бүс (FTA)-ийн харилцааг төрөөс батлагдсан худалдааны бодлогын баримт бичиг болон ДХБ-аас батлан гишүүн улсуудад мөрдүүлдэг олон улсын гэрээ хэлэлцээрээр зохицуулдаг. Талууд аль харилцаанд ямар олон улсын гэрээ, конвенц, эсхүл дотоодын хууль тогтоомж хэрэглэхийг хоёр талт, олон талт чөлөөт худалдааны гэрээнд нарийвчлан тусгадаг. Худалдааны талаар баримтлах бодлогын баримт бичгийг ДХБ-д нэгдэн орсон гэрээ, конвенцын дагуу хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэх зорилготой уялдуулан баталж хэрэгжүүлдэг. Хятад улс нь том чөлөөт худалдааны бүс (FTA)-ийн талаар баримтлах зорилго, зорилгоо дараах бодлогын баримт бичигт тусгажээ.

“Бүс ба зам” бодлого

БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жин Пин 2013 онд “Бүс ба Зам” бодлогын баримт бичгийг санаачилж, торгоны зам дагуу орших улс орнуудтай “хамтдаа худалдаа хийх, хамтдаа барьж байгуулах, хамтдаа ашиг хүртэх” зарчмын дагуу эдийн засгийн хамтын ажиллагааг эхлүүлэх, өргөжүүлэх, хамтдаа хөгжих уриалгыг дэвшүүлсэн. Уг санаачилгад дэлхийн 100 гаруй улс, бүсийн байгууллага нэгдсэн бөгөөд 40 гаруй улс хамтын ажиллагааны гэрээ байгуулаад байна. Энэхүү бодлогын хүрээнд Хятад улс торгоны зам дагуу орших улс орнуудтай 3 их наяд америк долларын худалдаа хийж, 459 тэрбум америк долларын хөрөнгө оруулалтыг бусад улсад хийжээ.

Хятад улс “Бүс ба зам” бодлогын хүрээнд Евроазийг зургаан коридороор холбох зорилго тавьсан. Хөгжил шинэчлэлийн хороо, Гадаад хэргийн яам, Худалдааны яам 2015.03.28-ны өдөр хамтран “Торгоны замын эдийн засгийн бүс ба XXI зууны далайн торгоны замыг хөгжүүлэх эрмэлзэл, үйл ажиллагаа” гэх баримт бичиг баталсан ба хуурай газрын олон улсын томоохон гарцад тулгуурлаж, зам дагуух том хотуудад түшиглэн, худалдаа, эдийн засаг, үйлдвэрлэлийн бүсийг хамтын ажиллагааны талбар болгон, Ази-Европын эдийн засгийн гүүрийг хамтран байгуулахаар заажээ. Үүнд:

- Баруун Хятад-Оросын зүүн хэсэгтэй холбосон коридор;
- Хойд Хятад-Оросын зүүн хэсэгтэй холбосон коридор;
- Хятад-Монгол-Оросын коридор;
- Хятад-Төв Ази-Баруун Азийн коридор;
- Хятад-Энэтхэгийн хойг, Хятад-Пакистаны коридор;
- Хятад-Энэтхэг-Бангладешийн коридор. Эдгээр коридороор эдийн засгийн идэвхтэй

Азийн орнуудыг эдийн засгийн өндөр хөгжилтэй Европ тивтэй холбож, хамтран хөгжиж, хамтран ашиг хүртэх зорилготой.



Зураг 8. Торгоны замын зураглал

Зургаан коридороор холбогдох улсууд:

1. Хятад болон Зүүн Азийн 11 улс: Монгол, Сингапур, Малайз, Индонез, Мьянмар, Тайланд, Лаос, Камбож, Вьетнам, Бруней, Филиппин;
2. Баруун Азийн 18 улс: Иран, Ирак, Турк, Сири, Йордан, Ливан, Израил, Палестин, Саудын Араб, Йемен, Оман, Арабын Нэгдсэн Эмират, Катар, Кувейт, Бахрейн, Грек, Кипр, Египетийн Синайн хойг;
3. Өмнөд Азийн 8 улс: Энэтхэг, Пакистан, Бангладеш, Афганистан, Шри Ланка, Мальдив, Балба, Бутан;
4. Төв Азийн 5 улс: Казахстан, Узбекистан, Туркменистан, Тажикистан, Киргизстан;
5. Орос улс болон Зөвлөлт холбоот улсын харьяанд байсан 6 улс: Орос, Украин, Беларусь, Гүрж, Азербайжан, Армени, Молдав;
6. Төв болон Зүүн Европын 16 улс: Польш, Литва, Эстони, Латви, Чех, Словак, Унгар, Словени, Хорват, Босни Герцеговина, Монтенегро, Серби, Албани, Румын, Болгар, Македон.

“Бүс ба зам” бодлогын 4 дүгээр бүлэгт олон улсын түвшний чөлөөт худалдааны бүсийн талаар тусгасан. Үүнд: худалдааны саад тотгорыг арилгах асуудалд Хятад улс анхаарал хандуулах бөгөөд энэ зорилтын хүрээнд худалдааг хөнгөвчлөх, торгоны зам дагуух улсуудтай чөлөөт худалдааны бүс байгуулах зорилт тавин ажиллана. Хамтрагч талуудтай харилцан мэдээлэл солилцох чадварыг нэмэгдүүлэх, харилцан хяналт тавихад хамтран ажиллах, гаалийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хилийн нэвтрэх байгууламжийг сайжруулах, хилийн нэг цонхны үйлчилгээ үзүүлэх байгууламжийн ажлыг хурдан гүйцэтгэх, хилээр нэвтрэх нэгж өртгийг бууруулах, чадварыг нэмэгдүүлэх, тарифын бус хязгаарлалтыг²¹ багасгах, техникийн шинжтэй худалдааны арга хэмжээний ил тод байдал болон худалдааны чөлөөт байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах зорилт тусгагджээ.

Хятад Улсын том чөлөөт худалдааны бүсийн гэрээ (FTA)

²¹ Тарифын бус хязгаарлалтад импортын татвараас гадна импортод хязгаарлалт тогтоож буй бүх хэлбэрүүд юм. Тарифын бус хязгаарлалтад квот тогтоох, төрөөс татаас олгох, демпингийн эсрэг арга хэмжээ авах зэрэг хамаарна.

Хятад Улс нь ДХБ-аас баталсан ГАТТ-ын 24 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу Мавритус, Гүрж, Солонгос, Чили, Пакистан, Зүүн өмнөд Азийн холбоо, Хонгконг, Макао, Малдив, Австрали, Швейцарь, Коста-Рика, Шинэ Зеланд зэрэг улстай чөлөөт бүсийн гэрээ байгуулсан бөгөөд Шри-Ланка, Израйл, Молдав, Панам зэрэг оронтой чөлөөт худалдааны гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж байна.

Хятад болон Солонгос улсын хооронд 2018 онд байгуулагдсан “FTA” буюу том чөлөөт худалдааны гэрээнд дараах агуулгыг тусгажээ:

- Бараа зах зээлд нэвтрэх журам, дотоодын татвар ногдуулалтын талаарх үндэсний нөхцөл (national treatment and market access for goods). Бараа бүтээгдэхүүнд үндэсний нөхцөл олгоно гэдэг нь гэрээний талууд ГАТТ-ын 3 дугаар зүйлд заасны дагуу гэрээний нөгөө талын бараа хилээр нэвтрэхэд “Үндэсний нөхцөл” (National treatment) олгодог байна. Өөрөөр хэлбэл; гэрээний талууд нөгөө талын бараанд ногдуулах татвар, хураамж нь өөрийн улсын бараа бүтээгдэхүүнд ногдуулах татвар, хураамжтай ижил байх юм. Зах зээлд нэвтрэх нөхцөл гэдэг нь талуудын бараа нөгөө улсын хилээр буюу зах зээлд нэвтрэхэд тавигдах нөхцөл, болзол, шаардлага юм. Тухайлбал; гаалийн татвар, бараа, хөрөнгө оруулалтын хэмжээ болон хөрөнгө оруулалт хийхэд хязгаарлах, хориглох салбар зэрэг татварын болон татварын бус худалдааны саад тотгорын талаарх зохицуулалтыг тусгаж, харилцан тохиролцсон байна;

- Гарал үүслийг тодорхойлох журам, түүнийг хэрэгжүүлэх үе шат (the rules of origin). Энэхүү бүлэгт гэрээний оролцогч талуудын хилээр нэвтрүүлэх бараа, онцлог бүтээгдэхүүний гарал үүслийг хэрхэн тодорхойлох талаар нарийвчлан зохицуулсан;

- Гаалийн бүрдүүлэлт болон худалдааг хөнгөвчлөх. Энэ бүлэгт гэрээний оролцогч талуудын олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт болон дотоодын гаалийн тухай хуулийн дагуу худалдааны бараа, түүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх, тэгш, ил тод байх, барааны ангилал, кодлолыг тодорхойлох, ямар олон улсын гэрээг хэрэглэх, үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгасан;

- Эрүүл ахуйн журам. Энэ бүлэгт гэрээний оролцогч талууд өөрийн гаалийн бүсийн хил доторх хүн, амьтан, ургамлын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй аюулыг хамгийн бага түвшинд хязгаарлах, энэ талаар авах арга хэмжээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, техникийн туслалцааны хувьд хамтран ажиллах, эрүүл ахуйн стандартыг дээшлүүлэх, туршлага солилцох талаар тусгасан;

- Техникийн шинжтэй худалдааны саад тотгор. Энэ заалтаар гэрээний оролцогч талууд худалдаанд нөлөөлж болзошгүй бүхий л стандарт, шаардлага болон уг харилцаанд хэрэглэх олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн хүрээ, зарчмыг тодорхойлсон. Мөн гэрээний нэг тал нөгөө талдаа тавьсан стандартын асуудалд нөгөө улсын хуулиар өндөр шаардлага тавьсан

тохиолдолд өөрийн улсын шаардлагын дагуу нөгөө талыг хүлээн зөвшөөрүүлэх талаар хүсэлт гаргаж болно гэж тохиролцсон байна;

- Худалдааны талаар авах арга хэмжээ. Энэ бүлэгт гэрээнд оролцогч талуудын гаалийн хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлсний улмаас тухайн бараа бүтээгдэхүүн гэрээний нөгөө талын гаалийн бүсэд их хэмжээгээр нэвтэрч, тухайн бүтээгдэхүүнтэй ижил дотоодын үйлдвэрлэлтэй харьцуулахад “хэт их” болсон, улмаар энэ нь ижил төрлийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх боломжийг хааж, ноцтой хохирол учруулах тохиолдолд гэрээний талууд хэрхэн арга хэмжээ авах, ямар олон улсын гэрээ, хууль тогтоомжийг үндэслэн шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгажээ;

- Үйлчилгээний салбарын худалдаа. Энэ бүлэгт гэрээнд оролцогч талууд үйлчилгээний салбар болох тээвэр, санхүү, аялал жуулчлал, барилга, бараа бүтээгдэхүүний түгээлт, онгоцны засвар үйлчилгээ зэрэг салбар дахь худалдааны харилцааг ямар олон улсын гэрээ, хууль тогтоомжоор зохицуулах хийгээд эдгээр салбарын зах зээлд нэвтрэхэд тавигдах нөхцөл, шаардлага, хязгаарлалт, ил тод байх болон бусад зарчим, үүрэг амлалтын талаар тусган зохицуулсан;

- Санхүүгийн үйлчилгээ. Энэ бүлэгт санхүүгийн салбарт үйлчилгээ үзүүлэх этгээдэд үзүүлэх худалдааны нөхцөл, зах зээлд нэвтрэхэд үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт, хязгаарлалт, хориглолт, дансны мэдээллийн нууцлалыг хамгаалах талаар өгсөн амлалт, санхүүгийн ил тод байдал, төлбөрийн систем ашиглалт, хяналт шалгалт болон уг асуудлаар үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар заасан;

- Харилцаа холбоо. Энэ бүлэгт гэрээний талууд харилцаа холбооны салбарын худалдаанд нөлөөлж болзошгүй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар заасан. Тухайлбал; харилцаа холбооны салбарын үйл ажиллагааны хүрээ, тусгай зөвшөөрөл олгох, далай доорх оптик кабелийн системийг хэрэглэх зарчим, цахилгаан холбооны нөөц хомсдох үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон маргаан шийдвэрлэх журмыг тусгасан;

- Иргэний хөдөлгөөн. Энэ бүлэгт гэрээний талуудын иргэн нөгөө талын хилээр нэвтрэх процесс, виз авах, сунгах явцыг хөнгөвчлөх, түр хилээр нэвтрэхийг зөвшөөрөх, иргэдийн хөдөлгөөнийг хариуцах зөвлөлийн статус, үйл ажиллагааны талаар болон ил тод байдал болон маргаан шийдвэрлэх журмыг заажээ;

- Хөрөнгө оруулалт. Энэ бүлэгт гэрээний оролцогч талууд нөгөө талын хөрөнгө оруулагчдад үзүүлэх хөнгөлөлт, нөхцөл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамгаалахад чиглэсэн авах арга хэмжээ, уг харилцааг зохицуулах олон улсын гэрээ, хэлэлцээр, дотоодын хууль тогтоомж, мөн хөрөнгө оруулалт ил тод байх зарчим, татвар, нөхөн олговор, хөрөнгө, мөнгийг хилээс гаргах, шилжүүлэх журам болон маргаан шийдвэрлэх журмыг тусгасан;

- Цахим худалдаа. Энэ бүлэгт ДХБ-аас батлагдсан олон улсын гэрээ, хэлэлцээр нь цахим худалдаанд нөлөөлөх үед авах арга хэмжээ, цахим зөвшөөрөл, цахим гарын үсэг, цахим

худалдан авалт, хувь хүний нууцын асуудал болон маргаан шийдвэрлэх арга зам, эдгээр харилцаанд баримтлах зарчим, татварын зохицуулалтын талаар заасан;

- Өрсөлдөөний бодлого. Гэрээний талууд шударга өрсөлдөх боломжийг хангах, шударга бус өрсөлдөгчийн үйлдлийг хориглох, худалдааг хөнгөвчлөх, эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор өрсөлдөөний бодлого хэрэгжүүлнэ гэж заасан. Өрсөлдөөний хууль, өрсөлдөөний асуудал хариуцсан байгууллага, баримтлах зарчим, ил тод байдал, мэдээлэл солилцох журам, техникийн хамтын ажиллагаа болон маргаан шийдвэрлэх журмын талаар заасан;

- Оюуны өмч. Энэ бүлэгт гэрээний талууд энэ гэрээ болон нэгдсэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу оюуны өмчийг үр дүнтэй, ил тод, ялгаварлалгүй хамгаалах, хадгалах, оюуны өмчийн өмчлөгчийн эрхийг (хэвлэн нийтлэх, барааны тэмдэг, олонд танигдсан барааны тэмдэг, түүний бүртгэл, патентын эрх, үндэсний болон ардын урлаг, соёл, ургамлын шинэ төрөл, сорт, загвар дизайн зохион бүтээх гэх мэт) зөрчих, хуурамчаар үйлдэх, хулгайлах, оюуны өмчийг зөрчсөн бүтээгдэхүүнийг хил, гаалиар нэвтрүүлэх зэрэг асуудалд авах хууль зүйн хариуцлага, оюуны өмчийн харилцаанд мөрдөх олон улсын гэрээ хэлэлцээр, энэхүү хэлэлцээрээр хамгаалагдахгүй биет бус оюуны бүтээлийн хүрээ болон оюуны өмчийн асуудал хариуцах хамтарсан зөвлөлийн зохион байгуулалт, чиг үүрэг зэргийг тусгасан;

- Байгаль орчин ба худалдаа. Гэрээний талууд хамтран байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, санхүүжилтийн талаар тусгасан;

- Эдийн засгийн хамтын ажиллагаа. Энэ бүлэгт гэрээний талууд эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, хөдөө аж ахуй, загас, мод, ган төмөр, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар, аялал жуулчлал, далайн тээвэр, эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг салбарт хамтран ажиллах, ирээдүйд хамтран ажиллах боломжит хүрээг тодорхойлох, үүнтэй холбоотой чиг үүргийг хариуцах нэгжийн зохион байгуулалтын талаар заасан;

- Ил тод байдал. Гэрээний талууд гэрээнд заасан үүргээ цаг тухайд нь зохих ёсоор гүйцэтгэхэд нь саад учруулахгүйн тул; талуудын шийдвэр, арга хэмжээний талаар нийтэд нээлттэй мэдээлэх, мэдэгдэл хүргүүлэх процессыг тусгасан;

- Удирдлага, зохион байгуулалт. Хятад, Солонгос улс нь чөлөөт худалдааны бүсийн асуудлыг хариуцсан хамтарсан хороо байгуулсан. Энэхүү хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 1.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг тайлбарлах; 2.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, амлалт, санаачилгыг сайжруулах санал гаргах; 3.Гэрээний хэрэгжилтийг гүйцэтгэх бүх байгууллага, зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих; 4.Гэрээний хэрэгжилтийг

үндэслэн талуудын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого боловсруулах; 5.Гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбоотой үүссэн асуудлыг шийдвэрлэх.

Чөлөөт худалдааны бүсийг хамтарсан хороо нь байнгын болон түр хороо байгуулж болох ба чиг үүргээ шилжүүлэн гүйцэтгүүлж болдог. Хороо нь жилд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд хурал зарлан хуралдуулна. Хурлыг талуудын нутаг дэвсгэрт ээлжлэн зохион байгуулж, хурал зохион байгуулагч тал хурлыг удирддаг. Хурлын даргын үүргийг Хятад талаас Хятадын Худалдааны сайдын; Солонгос талаас Солонгосын Худалдаа, үйлдвэрлэл, байгалийн баялгийн сайдын томилсон этгээд хэрэгжүүлнэ. Хороо нь дараах асуудлаар 12 салбар хороо байгуулан ажилладаг:

- 1.Барааны худалдааны хороо;
- 2.Үйлчилгээний худалдааны хороо;
- 3.Санхүүгийн үйлчилгээний хороо;
- 4.Иргэний хөдөлгөөн зохицуулах хороо;
- 5.Гаалийн хороо ;
- 6.Хилийн гадна байх боловсруулах бүсийн хороо;
- 7.Худалдааны арга хэмжээ хариуцсан хороо;
- 8.Эрүүл ахуй ба ургамлын асуудал хариуцсан хороо;
- 9.Техникийн шинжтэй худалдааны саад тотгор хариуцсан хороо;
- 10.Оюуны өмчийн асуудал хариуцсан хороо;
- 11.Байгаль орчин ба худалдаа хариуцсан хороо;
- 12.Эдийн засгийн хамтын ажиллагаа хариуцсан хороо.

-Маргаан шийдвэрлэх. Энэ бүлэгт гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл зохих ёсны дагуу гүйцэтгээгүй бол нэхэмжлэгч тал өөрийн сонгосон улсын маргаан шийдвэрлэх байгууллагад нэхэмжлэл гаргах, зөвшилцөх, мэргэжлийн ажлын хэсэг байгуулах, мэргэжлийн дүгнэлт гаргуулах, нөхөн төлбөр олгох, гэрээний үүргийг дуусгавар олгох, тайлбар гаргах зэрэг хэрэг хянан хэлэлцэх журмыг тусгасан. Гэрээнд талуудын гэрээний нөгөө талд үзүүлэх гаалийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах бараа бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ, хэрэгжих хугацаа, талуудын өгсөн нарийвчилсан үүрэг амлалт, бараа бүтээгдэхүүний жагсаалт, бусад маягтыг хавсаргадаг болно.

Хятад болон Сингапур улсын хооронд 2010 онд байгуулсан чөлөөт худалдааны гэрээнд (FTA) бараа бүтээгдэхүүний худалдаа, гарал үүсэл, гаалийн бүрдүүлэлт, шат дараалал, худалдааны талаар авах арга хэмжээ, техникийн шинжтэй худалдааны саад тотгор, эрүүл ахуй, иргэний нэвтрэх, гарах хөдөлгөөн, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагаа, маргаан шийдвэрлэх журам зэрэг асуудлыг тохиролцсон байна.

Хятад болон Швейцар улсын хооронд 2018 онд байгуулсан чөлөөт худалдааны гэрээнд худалдааны нөхцөл, татварын хөнгөлөлт, импортын барааны гаалийн тариф, хилээр нэвтрэх, гарах хориглолт, хязгаарлалт, бараа бүтээгдэхүүний гарал үүслийн зарчим, тавигдах шалгуур, нөхцөл, баталгаажуулалт, гаалийн бүрдүүлэлт болон хөнгөвчлөх журам, худалдааны талаар авах арга хэмжээ, техникийн шинжтэй худалдааны саад тотгор, эрүүл ахуй, үйлчилгээний салбарын худалдаа, хөрөнгө оруулалтыг сайжруулах, шударга өрсөлдөөн, оюуны өмчийг хамгаалах, байгаль орчин, эдийн засгийн хамтын ажиллагаа, чөлөөт бүсийг хариуцах эрх бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт, маргаан хянан шийдвэрлэх болон бусад асуудал гэсэн агуулгыг тодорхойлжээ.

Дээр дурдсан гурван гэрээнд бүтэц, агуулгын зарчмын ялгаа байхгүй бөгөөд “FTA” буюу том чөлөөт худалдааны гэрээгээр дараах асуудлыг нарийвчлан тохиролцдог байна:

- бараа, үйлчилгээний салбарт худалдааны ямар нөхцөлийг нөгөө талдаа олгох,
- гарал үүслийг хэрхэн тодорхойлох, барааны гаалийн бүрдүүлэлтийн шат дамжлагыг хөнгөвчлөх,
- гаалийн тарифыг хэрхэн бууруулах, чөлөөлөх,
- дотоодын зах зээлийг хэрхэн хамгаалах, дотоод болон олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн стандарт нөхцөл,
- үйлчилгээний салбарын зах зээлд нэвтрэхэд тавигдах шаардлага, энэ харилцааг зохицуулах хууль журам,
- иргэд чөлөөт бүсийн хилээр нэвтрэх, гарах журам, түүнийг хөнгөвчлөх,
- чөлөөт худалдааны бүс дэх хөрөнгө оруулалт, эдийн засгийн хүрээнд хамтран ажиллах боломж, хүрээг тодорхойлох,
- оюуны өмчийг хамгаалах, олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц,
- байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах талаар хамтран ажиллах,
- чөлөөт бүсийн асуудал хариуцсан нэгжийн зохион байгуулалт, бүтэц, статус, удирдлага, хяналт, чиг үүрэг.

Жижиг чөлөөт худалдааны бүс (FTZ)

Жижиг чөлөөт худалдааны бүс (FTZ)-ийн харилцааг улсаас батлагдсан бодлогын баримт бичиг, хууль, бүсийн ерөнхий төлөвлөгөө, журам болон орон нутгийн удирдлагаас батлагдсан захиргааны актаар зохицуулж байна.

Чөлөөт бүсийн тухай бие даасан хууль

Хятад улс нь нийт улсын хэмжээнд мөрдөх Чөлөөт бүсийн тухай бие даасан хууль батлаагүй бөгөөд харин 2021 оны 6 дугаар сард Хайнаны чөлөөт боомтын тухай хуулийг БУАИХТХБХ-оос баталсан байна. Энэ хууль нь зөвхөн Хайнан муж дахь чөлөөт худалдааны боомтын харилцаанд үйлчилнэ. Хятад улс нь чөлөөт худалдааны бүсийг хөгжүүлэхдээ “аль болох” бодлогын чөлөөт байдлыг хэрэгжүүлэхийг зорилго болгодог ба түүнийг “хэт хатуу” хуульчлах нь чөлөөт хөгжилд саад учруулна гэж үздэг. Иймд орон нутагт эрхийг нь өгч тухайлсан харилцаа бүрт тусгай журам, төлөвлөгөө гарган мөрдүүлдэг. Хайнаны чөлөөт худалдааны боомтын тухай хууль нь нийт 8 бүлэг, 57 зүйлээс бүрдэнэ. Хууль нь ерөнхий зохицуулалттай бөгөөд нарийвчилсан харилцааг зохицуулах журам батлах эрхийг ЗГ-ын холбогдох яам, орон нутгийн удирдлагад эрх олгон шилжүүлсэн.

Чөлөөт бүсийн харилцааг зохицуулах журам

Хятад улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 73, 74 дүгээр зүйлд хэрэв эдийн засгийн онцгой бүсийн талаар зохицуулах тусгайлсан хууль байхгүй бол БУАИТХБХ-аас эрх авсны үндсэн дээр орон нутгийн удирдлага журам батлан мөрдүүлж болно гэж заасан. Тухайлбал; Шанхай хотын Ардын Их Хурлын Төлөөлөгчдийн Байнгын хорооны 14 дүгээр хурлаар Шанхай хотын Чөлөөт худалдааны туршилтын бүсийн журмыг баталсан. Энэхүү журам нь 9 бүлэг, 57 зүйлтэй. Энэ журмаар чөлөөт бүсийн удирдлагын бүтэц, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх, санхүүжилт, татвар, хяналтын асуудлыг зохицуулсан байх ба чөлөөт бүсийн бүтээн байгуулалт, хэрэгжилтийн талаар “харьцангуй” нарийвчилсан зохицуулалт хийсэн байна. Хятад улсад худалдааны чөлөөт бүс бүрд тухайн харилцааг зохицуулсан журам батлан мөрдүүлдэг.

Орон нутгийн эрх бүхий байгууллагаас баталсан бусад захиргааны акт

Дээр дурдсан чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө, журмаас гадна эдгээр баримт бичиг, журмаар зохицуулагдаагүй зарим харилцаа, эсхүл илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай асуудал, зорилтыг Худалдааны яам, орон нутгийн удирдлагаас батлагдсан дүрэм, журам, захиргааны акт, шийдвэрээр зохицуулдаг. Тухайлбал; Худалдааны яамнаас 2021 оны 163 дугаар шийдвэрээр Өвөр Монгол, Лиаонин, Жилин зэрэг газрын хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны хороонд дараах чиглэлээр анхаарч ажиллах үүрэг даалгавар өгчээ:

-Бүс ба зам санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд хил залгаа улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, Орос, Монгол, Казакстан, Вьетнам, Лаос зэрэг оронтой эдийн засгийн хамтын ажиллагааны түвшинг гүнзгийрүүлэх, Казакстан, Лаостай байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх;

-Хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд нэвтрэх импортын түүхий эд, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс дэх боомт, зам тээвэр, гааль, иргэний хөдөлгөөний асуудал хариуцсан байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, бүсийн ложистикийн төв дэх барааны транзит, дамжуулан тээвэрлэх, тараах чадварыг нэмэгдүүлэх;

-Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хариуцан зохион байгуулах шинэ арга хэлбэрийг турших, хэрэгжүүлэхийг дэмжих.

Хятад улсын хөрөнгө оруулалтын орчин

Хятад улс гадаад зах зээлд нээлттэй болсноос хойш нийт 109 оронтой хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээ, 107 улстай давхар татвар ногдуулахаас зайлсхийх гэрээ байгуулжээ.²² Хятад улс нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалтын гурван хууль гэж нэрлэх “Хятад, гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн тухай хууль”, “Гадаадын хуулийн этгээдийн тухай хууль”, “Хятад, гадаадын хуулийн этгээд хамтран үйл ажиллагаа эрхлэх тухай хууль”-ийг тус тус батлан мөрдүүлсэн.

Харин 2019 онд БУАТИХБХ-аар “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийг батлагдсанаар дээрх гурван хууль хүчингүй болсон. Энэ хуулиар Хятад улс гадаадын хөрөнгө оруулалтын шинэ тогтолцоог тодорхойлж “Гадаадын хөрөнгө оруулалт зах зээлд нэвтрэхээс өмнө үндэсний нөхцөл” олгох болон “сөрөг жагсаалт”-ын аргаар удирдах тогтолцоог бий болгосон. Өөрөөр хэлбэл; гадаадын иргэн, хуулийн этгээд Хятадын зах зээлд хөрөнгө оруулахад дотоодын хөрөнгө оруулагчдаас дутуугүй нөхцөл олгох (хөрөнгө оруулахад тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, олгох хөнгөлөлт гэх мэт) бөгөөд харин сөрөг жагсаалт буюу гадаадын хөрөнгө оруулалт хийхийг хязгаарласан, эсхүл хориглосон салбарыг тодорхой дурдах замаар дотоодын стратегийн салбарыг хамгаалах, дэмжих бодлого хэрэгжүүлдэг. Сөрөг жагсаалт 2020.06.24-ний өдөр шинэчлэн батлагдсан бөгөөд 2021.07.23-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж байна. Энэ жагсаалтаар 33 нэр төрлийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлаж, зарим

²² <http://images.mofcom.gov.cn/wzs/202101/20210106142113814.pdf>

хэсэгт нь хориглосон байна. Энэ жагсаалтад багтаагүй салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийх тохиолдолд дотоодын иргэний адил нөхцөл эдэлнэ.


Түүнчлэн, Хятадын Хөгжил шинэтгэлийн хороо, Худалдааны яамнаас хамтран “Чөлөөт худалдааны бүсэд гадаадын хөрөнгө оруулалтын онцгой зохицуулалтын журам (сөрөг жагсаалт)”-ыг 2020 онд баталсан. Гадаадын хөрөнгө оруулагчид дотоодын зах зээл болон чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийхэд дээр дурсан хоёр сөрөг жагсаалтаас гадна 2019 онд батлагдсан “Дотоодын зах зээлд нэвтрэх сөрөг жагсаалт”-ыг (Market access negative list) мөн мөрддөг.

БНХАУ-ын чөлөөт бүсийн хилийн дотор компани байгуулах бол Худалдааны яамнаас батлагдсан “Чөлөөт худалдааны бүсэд гадаадын хөрөнгө оруулалтыг бүртгэх журам”-ыг мөрдөнө.²³ Энэ журмын 3 дугаар зүйлд “чөлөөт бүсийг хариуцах, удирдах байгууллага нь чөлөөт бүс дэх гадаадын хөрөнгө оруулалтыг хариуцан бүртгэнэ” гэж заасан. Хятад улс нь дэлхийн бусад оронтой адил олон төрлийн татвараас бүрдсэн холимог татварын тогтолцоотой. Одоо хэрэгжиж буй хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчдад нийт 18 төрлийн татвар ногдуулж байна.

Эдийн засгийн онцгой бүсийн үйл ажиллагааны оролцогчид

Институтийн бүтэц, зохион байгуулалтын загварыг хөндөхийн өмнө чөлөөт бүсийн үйл ажиллагаанд “оролцогч” этгээд болон тэдний хэрэгжүүлэх ажил үүргийн талаар авч үзнэ. эдийн засгийн онцгой бүс нь дараах дөрвөн оролцогчдоос бүрдэнэ: 1.Зохицуулагч, 2.Өмчлөгч, 3.Хөгжүүлэгч 4.Гүйцэтгэгч (менежер).

Зураг 9 ЭЗОБ-ийн оролцогчид



Эдгээр оролцогчид нь эдийн засгийн онцгой бүсийн харилцаанд дараах үүрэг гүйцэтгэдэг:

1.Зохицуулагч (regulator): Бүсийн зохицуулагч нь тухайн улсын ЗГ, чөлөөт бүсийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, захиргааны нэгж байх ба дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг:²⁴

ЗГ-ын нийтлэг чиг үүрэг:

²³ 中华人民共和国自由贸易试验区外商投资备案管理办法

²⁴ Institutional structure of Special Economic Zones, Mohak Mangal, International Growth Centre, 2018

-Эдийн засгийг хөгжүүлэх, экспортыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, нийлүүлэгчийн уялдаа холбоог хангах зорилгоор эдийн засгийн онцгой бүс байгуулах байршил, төрөл, тоо хэмжээг тодорхойлж, бүс байгуулах шийдвэр гаргах;

-эдийн засгийн онцгой бүс-ийн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд ерөнхий хяналт тавих;

-зарим тохиолдолд эдийн засгийн онцгой бүс-ийг дэмжих зорилгоор зам барих, засах, цахилгаан эрчим хүчээр хангах зэрэг гадаад дэд бүтцийг хөгжүүлэх;

-эдийн засгийн онцгой бүс-ийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд бие даасан этгээдээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэх;

-эдийн засгийн онцгой бүс-ийн стратеги төлөвлөгөөг боловсруулах;

-эдийн засгийн онцгой бүс байгуулах саналыг нарийвчлан хянах, саналд хөндлөнгийн судалгааны байгууллагаар шинжилгээ хийлгэх, эдийн засгийн онцгой бүс байгуулах.

2.Өмчлөгч (owner): Өмчлөгч гэж эдийн засгийн онцгой бүсийн газар өмчлөгчийг ойлгох бөгөөд газар өмчлөгч нь төр, эсхүл хувийн хэвшлийн хуулийн этгээд байна.

3.Хөгжүүлэгч (developer): Бүсийг хөгжүүлэгч нь тухайн бүсийг бүтээн байгуулах, хөгжүүлэх асуудлыг хариуцсан төрийн байгууллага, хувийн хэвшлийн хуулийн этгээд, эсхүл төр-хувийн хэвшлийн түншлэгч байна.

Дэлхийн ихэнх улсад эдийн засгийн онцгой бүс гэдэг нь харьцангуй шинэ ойлголт бөгөөд 2015-2019 оны хооронд нийт бүсийн 20 орчим хувь болох 1000 гаруй эдийн засгийн онцгой бүс байгуулагдсан байна.²⁵ Иймд эдийн засгийн онцгой бүс-ийн асуудал хариуцан удирдах, хөгжүүлэх дотоодын хүний нөөц хомс тул хөгжиж буй олон улс энэхүү орон зайг нөхөхийн тулд туршлага, нөөц бололцоо бүхий гадаад, дотоодын хувийн хэвшилд ханддаг. 2008 оны тооцооллоор хөгжиж буй болон шилжилтийн үеийн улсын эдийн засгийн онцгой бүс-ийн 62 хувийг хувийн хэвшлийн хөгжүүлэгчид байгуулжээ.²⁶ Төрөөс хувийн хэвшлийн сонирхлыг татахын тулд санхүү, газрын давуу эрх, хөрөнгө оруулалт, гааль, татварыг хөнгөвчлөх зэрэг тусгай дэглэм бүхий урамшууллын бодлогыг хэрэгжүүлдэг.

4.Гүйцэтгэгч, эсхүл менежер (operator or manager): Гүйцэтгэгч, эсхүл менежер нь бүсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах үүрэг бүхий этгээд байх бөгөөд хөгжүүлэгчээс тусдаа хуулийн этгээд байж болно. Өөрөөр хэлбэл; бүсийн хөгжүүлэгч нь бүсийн гүйцэтгэгчийн үүргийг давхар хэрэгжүүлж болох ба тусдаа хуулийн этгээд ч байж болно.

²⁵ Special economic zones: methodological issues and definition, page 144, François Bost, 2019

²⁶ Special economic zones, performance, lessons learned and implications for zone development, 2008, World bank

Ихэнх тохиолдолд эдийн засгийн онцгой бүсийн хөгжүүлэгчид бүсийн өдөр тутмын ажлыг хариуцан эрхэлдэг ба өөрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болдог. тухайлбал: хөгжүүлэгч нь эдийн засгийн онцгой БҮС-ийг ус, дулаан, цахилгаан, холбоогоор хангах зэрэг хөгжүүлэгчийн чиг үүргээ гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг.

КАЗАКСТАН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ БҮСИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАХ ХҮРЭЭ, АГУУЛГА

Хятадын гаалийн онцгой дэглэм бүхий бүсийн нэг төрөл нь хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс болно. Хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс гэдэг нь өөрийн орны хилийн дагуух бүсэд хил залгаа нэг, эсхүл хэд хэдэн улстай бүс нутгийн давуу тал, ижил төстэй байдлын үндсэн дээр худалдаа, бүтээгдэхүүн боловсруулалт, гааль, татварын асуудалд харилцан хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлэхээр байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс юм.²⁷ Энэ бүс нь тээвэр ложистик, аялал жуулчлал, бүтээгдэхүүн боловсруулах гэх мэт олон талт хамтын ажиллагааны цогцолбор бүс гэдгээр онцлогтой бөгөөд хамтрагч талууд худалдааны хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлэн, хамтын ажиллагааны бүс дэх санхүүгийн урсгалыг нэмэгдүүлж, эдийн засгаа хөгжүүлдэг. Хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нь дараах онцлог шинжтэй:

1. Хоёр ба түүнээс дээш бие даасан бүрэн улсын хил залгаа бүсэд байгуулна;
2. Хамтын ажиллагаа бүсийн хэмжээг тус улс өөрөө тогтоон тодорхойлох ба нийлээд нэг бүс болно;
3. Бүсийн үйл ажиллагааг хоёр улс хамтран удирдана;
4. Хоёр улсын хөнгөлттэй бодлогод хамрагдана;
5. Бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж хоёр зах зээлийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг.

Хятад болон Казакстан улс 2004 онд “Хятад-Казакстаны Хоргос хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны төвийн гэрээ”-г байгуулсан ба 2006 оноос төвийн бүтээн байгуулалтын ажил эхэлсэн. Хятадын ЗГ-аас 2011 онд Хоргос дахь эдийн засгийн хөгжлийн төв байгуулахыг дэмжих тухай 33 дугаар тогтоол гаргасан ба Хоргос дахь эдийн засгийн нээлттэй хөгжлийн бүсийн талбайн хэмжээг 73 км.кв гэж тогтоосон. Үүний дотор Хятад-Казакстаны хамтын ажиллагааны төв 13.36 км.кв талбайг эзэлнэ. Хятадын талаас хамтын ажиллагааны

²⁷ 麻烦, 国内外跨境经济合作区模式比较分析与经验借鉴, 2020

төвийн бүтээн байгуулалтад нийт 200 гаруй тэрбум юаны хөрөнгө оруулалт хийсэн. Энэхүү хамтын ажиллагааны бүсэд худалдаа, үзэсгэлэн, бараа хадгалалт, зочид буудал, санхүүгийн үйлчилгээ, олон улсын үзэсгэлэн худалдаа, хурал зөвлөгөөн зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг. Хятадын ЗГ-аас бүсийн хөгжлийг дэмжих зорилгоор 9.73 км.кв талбай бүхий экспорт ложистикийн төв, агуулах зэрэг дагалдах байгууламжийг барьсан. Дагалдах байгууламжийн нутаг дэвсгэр дэх татвар, гадаад мөнгөн тэмдэгт, удирдлага, хяналт, зохион байгуулалтын бодлого нь Хятадын Жүхай-Макаогийн хил дамнасан аж үйлдвэрийн парк дээр хэрэгжүүлдэг бодлоготой ижил юм. Хятадын ЗГ-ын 2011 оны 33 дугаар тогтоолоор хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг дэмжихээр заасан байдаг.

Казакстан Улс нь эдийн засгийн онцгой бүс болон аж үйлдвэрийн бүсийн тухай хууль (Law on special economic and industrial zones in the Republic of Kazakhstan)-ийг анх 1996 онд батлан мөрдүүлсэн ба 2011, 2019 онд шинэчлэн найруулсан. Энэ хуулиар дараах асуудлыг зохицуулна:²⁸

Хүснэгт 6. Казакстан улсын эдийн засгийн онцгой бүс, аж үйлдвэрийн бүсийн хуулийн бүтэц

1 дүгээр бүлэг	эдийн засгийн онцгой бүсийн нэр томъёоны тайлбар, эдийн засгийн онцгой бүс байгуулах зорилго
2 дугаар бүлэг	эдийн засгийн онцгой бүсийн талаарх төрийн байгууллагын чиг үүрэг
3 дугаар бүлэг	эдийн засгийн онцгой бүс байгуулах, нээх, хаах, эдийн засгийн онцгой бүсэд үйл ажиллагаа эрхлэгчдэд тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргах, зөвшөөрөл олгох, бүртгэх
4 дүгээр бүлэг	эдийн засгийн онцгой бүс хариуцсан байгууллага, нэгж байгуулах, бүсийн оролцогчид, тэдгээрийн чиг үүрэг, бүсийн санхүүжилт
5 дугаар бүлэг	эдийн засгийн онцгой бүсийн нэгдсэн удирдлагын төв, чиг үүрэг
6 дугаар бүлэг	эдийн засгийн онцгой бүсийн менежментийн компани, чиг үүрэг
7 дугаар бүлэг	Аж үйлдвэрлэлийн бүсийн менежментийн компани, чиг үүрэг
8 дугаар бүлэг	Татвар, гааль, гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, бүсийн оролцогчдод олгох баталгаа зэрэг тусгай дэглэм
9 дүгээр бүлэг	Хуулийн хариуцлага

²⁸ <https://adilet.zan.kz/eng/docs/Z1100000469>

Явцын дүгнэлт

БНХАУ нь эдийн засгаа төрөлжүүлэх, өргөжүүлэх, сайжруулах зорилгын хүрээнд олон улсын түвшний болон улсын түвшний чөлөөт худалдааны бүс байгуулан, амжилттай удирдан явуулж байна. Хятад улсад дотоодын хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдсан эдийн засгийн онцгой бүс нь улсын эдийн засгийн үзүүлэлтэд эерэг нөлөө үзүүлж байна.

Эдийн засгийн онцгой бүсийг өөрийн орны онцлог, бодлого, хөгжлийн төлөвлөгөө, газар зүйн байрлал зэргээс хамааран олон төрөлд ангилж, эдийн засгийн онцгой горимоор үйл ажиллагааг нь зохицуулж, худалдаа, хөрөнгө оруулалтын хөнгөвчлөх бодлого хэрэгжүүлдэг. Энэ нь эдийн засгийн хөгжлийг хурдасгах, төгс тогтолцоог эрэлхийлэн турших гэсэн үндсэн хоёр зорилготой байна. Иймд улсаас чөлөөт бүсийн эрх зүйн орчны талаар баримтлах бодлого нь харьцангуй чөлөөтэй байх бөгөөд бүсийн хөгжлийн асуудлыг хариуцан, удирдах эрхийг Засгийн газар болон орон нутагт олгосон.

Хятад улсад чөлөөт бүсийн асуудлыг зохицуулсан улсын хэмжээнд мөрдөх бие даасан хууль байхгүй бөгөөд чөлөөт бүс тус бүрд өөрийн онцлогийг шингээсэн төлөвлөгөө, журам батлан мөрдүүлдэг. Энэ төлөвлөгөө, журамд эдийн засгийн онцгой бүсэд хэрэгжүүлэх онцгой горим, хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар тусгадаг. Хятад улс нь чөлөөт бүсэд сөрөг жагсаалтын арга буюу хязгаарласан, хориглосон салбар, бараа бүтээгдэхүүний хүрээг тодорхойлж, бусад салбарт нээлттэй байх тогтолцоогоор хяналт хэрэгжүүлдгээрээ онцлогтой болно.

Анхаарах шаардлагатай нэг зүйл нь орон нутгаас батлагдсан чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө, журамд тусгагдсан гаалийн бүрдүүлэлт, тарифийн асуудал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу БУАТИХБХ болон Байнгын хорооноос заавал хууль батлах замаар шийдвэрлэх асуудлын хүрээнд хамаарна. Иймд орон нутгийн түвшинд батлагдсан чөлөөт бүсийн тухай ерөнхий төлөвлөгөө, журамд заасан гаалийн тариф, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх зохицуулалт нь Хятад улсын Хууль тогтоомжийн тухай хуультай нийцэхгүй байна. Харин 2021 онд Хайнаны чөлөөт боомтын тухай хуулийг БУАТИХ-аас хэлэлцэн баталсан нь энэ алдааг залруулсан алхам болсон байна.

Хүснэгт 7. ЭЗОБ-ийн хуулийн харьцуулалт /БНХАУ, Монгол улс/

ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ БҮС-ийн хуулийн зохицуулах хүрээ	Монгол	Хятад
Бүсийн тодорхойлолт	✓	✓
Эдийн засгийн онцгой бүс байгуулах зорилго	✓	✓
Эдийн засгийн онцгой бүсийн төрөл		✓
Бүсийн удирдлага, чиг үүрэг	✓	✓
Бүс байгуулах, нээх, хаах	✓	✓

Бүсийн оролцогчдын зохицуулалт	-	
Гаалийн тусгай дэглэм	✓	✓
Татварын тусгай дэглэм	✓	✓
Визний тусгай дэглэм	✓	✓
Хөрөнгө оруулалтыг дэмжих	✓	✓
Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт	✓	✓
Бүсийн оролцогчдод олгох баталгаа		✓
Бүртгэлийн журам	✓	✓
Чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны төрөл, сөрөг жагсаалт	✓	✓
Газрын харилцаа	✓	✓
Дэд бүтэц	✓	✓
Санхүүжилт, төсөв	✓	✓
Дуудлага худалдааны журам	✓	
Хүний нөөцийн журам		✓
Хорио цээр, хяналт шалгалт	✓	✓
Бараа, бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, хадгалах журам		
Эдийн засгийн онцгой бүс бодлогын туршилт хэрэгжүүлэх зохицуулалт		✓
Оюуны өмчийг хамгаалах		✓
Байгаль орчныг хамгаалах		✓
Инновацыг дэмжих		✓
Бараа тээвэрлэлтийн журам		✓
Аялал жуулчлалыг дэмжих		✓
Бүсийн аюулгүй байдлыг хангах	✓	✓
Хил дамнансан цахим худалдан авалтын зохицуулалт		✓
Шударга өрсөлдөөний журам		✓

Чөлөөт бүс үүсэж хөгжөөд 300 орчим жил өнгөрч байгаа бөгөөд 1950-иад оноос олон улсын эдийн засгийн харилцааны салшгүй хэсэг болжээ. Чөлөөт бүс нь тус улсын бусад хэсэгт үл хэрэглэгдэх эдийн засгийн хөнгөлөлт, урамшууллын онцгой системийг багтаасан үндэсний эдийн засгийн нэг хэсэг байдаг. Худалдааны чөлөөт бүс, аж үйлдвэрлэлийн чөлөөт бүс, техник нэвтрүүлэлтийн чөлөөт бүс, цогцолбор чөлөөт бүс гэсэн үе шатаар чөлөөт бүс нь хөгжсөн бөгөөд 1990-ээд оноос эдийн засгийн цогцолбор чөлөөт бүсийн үйл ажиллагаа эрчимжсэн.

Чөлөөт бүсийг “FTA” буюу том чөлөөт худалдааны бүс, “FTZ” буюу жижиг чөлөөт худалдааны бүс хэмээн ерөнхийд нь хоёр ангилан үздэг. Том чөлөөт худалдааны бүс нь олон улсын гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр буюу ДХБ-аас тавьсан шаардлагын дагуу, тэдний хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрч байгуулагддаг. Жижиг чөлөөт худалдааны бүс нь дотоодын хууль тогтоомжид үндэслэн байгуулагддаг. Том чөлөөт худалдааны бүс нь экспортод чиглэсэн, жижиг чөлөөт худалдааны бүс нь цогцолбор байх хандлага түгээмэл байна.

Эдийн засгийн онцгой бүсийг амжилттай хөгжүүлэхэд эдийн засгийн хөнгөлөлт, чөлөөлөлттэй дүйцэхүйц ач холбогдолтой хүчин зүйл нь бодлогын тогтвортой байдал, төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдэлгүй байх явдал юм. Бодлогын тогтвортой байдал, мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал, хариуцлагын механизм, бие даасан байдлын зарчмыг дагаж мөрдөх нь хөрөнгө оруулалт татахад эерэг нөлөөтэй байдаг.

Хятад улс эдийн засгийн онцгой бүсийн хуульгүй боловч эдийн засгийн онцгой бүсдээ тохирох төлөвлөгөө, журам гарган хэрэгжүүлж байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Чөлөөт бүс гэдэг нь тухайн улс оронд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид зааснаас илүү хөнгөлөлттэй тусгай дэглэм үйлчлэх тодорхой хил хязгаар бүхий эдийн засгийн бүсийг ойлгоно. Эдийн засгийн онцгой бүсийг дотор нь бүс байгуулах зорилго, үйл ажиллагааны төрлөөс нь хамааран худалдааны чөлөөт бүс, аж үйлдвэрлэлийн чөлөөт бүс, техник нэвтрүүлэлтийн чөлөөт бүс, эдийн засгийн чөлөөт бүс, цогцолбор бүс гэх мэтчилэн төрөлжүүлдэг. Монгол Улсын эдийн засгийн онцгой бүсийн харилцааг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулж байна. Гэтэл “чөлөөт бүс” гэдэг нь эдийн засгийн онцгой бүсийн зөвхөн нэг төрөл ба худалдаа, шилжүүлэн ачих, дахин экспорт хийх зорилгоор байгуулагдсан бараа бүтээгдэхүүн агуулах, хадгалах, түгээх байгууламж бүхий бүс юм.

Монгол Улсын хэмжээнд нийт гурван чөлөөт бүс байдаг. Алтанбулагийн чөлөөт бүсээс бусад нь үйл ажиллагааны хувьд байнгын, тогтвортой болж хараахан чадахгүй байна. Иймд манай улсын хувьд бие даасан яам, эсхүл агентлаг байх шаардлагагүй тул уг асуудлыг эрхэлсэн Сайдын дэргэд чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажлын алба, эсхүл хороо байгуулах нь тохиромжтойг бид харж байна.

Чөлөөт бүсийн үйл ажиллагаанд төр оролцох эсэх нь төр эдийн засгийн чөлөөт бүсэд ямар статустай оролцож, ямар үүрэг гүйцэтгэж байгаагаас хамаарна. Үүний тулд чөлөөт бүсийн харилцаанд төр нь зохицуулагч, өмчлөгч, хөгжүүлэгч, гүйцэтгэгчийн аль болохыг тодорхойлсон байх шаардлагатай. Зохицуулагч нь эдийн засгийн онцгой бүсийн бодлого, төлөвлөлтөөр хангах этгээд бол өмчлөгч нь бүсийн байрлах газрын өмчлөгч байдаг. Хөгжүүлэгч нь бүсийн ерөнхий төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэхийн зэрэгцээ гүйцэтгэгчийн үүргийг мөн гүйцэтгэж болдог. Төрийг төлөөлөн ихэнх улсад Засгийн газа эсхүл түүний эрх олгосноор худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажилладаг. Монгол Улсын хувьд иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч тул төр, түүний эрх олгосон байгууллага нь өмчлөгчийн хувиар, мөн зохицуулагчийн хувиар оролцох боломжтой.

Улс бүр эдийн засгийн чөлөөт бүс байгуулахдаа өөрийн орны улс төр, эдийн засаг, нийгмийн байдлыг харгалзан үзэж, бүс байгуулах зорилго, зорилтоо тодорхойлсны үндсэн дээр түүнтэй уялдуулан тохирсон загварыг ашиглан бүсийн институтийн бүтцийг тодорхойлдог хандлага дэлхий нийтэд тогтсон байна.

Чөлөөт бүсийн үйл ажиллагаа нь худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, зам тээвэр, гааль, татвар зэрэг олон талын харилцааны уялдааг хангахыг шаарддаг тул эдгээртэй холбоотой асуудлыг шуурхай шийдвэрлэх, салбар хоорондын бодлогын уялдааг хангахад ач холбогдолтой гэж үзэж байна. Чөлөөт бүс байгуулах зорилго, зорилт хоорондоо харилцан адилгүй тул бүс

бүрийн онцлогийг бүрэн хамарсан хуулийн зохицуулалт хийх боломжгүй юм. Иймд хуулийг аль болох ерөнхий байдлаар боловсруулж, тухайлсан харилцааг зохицуулах журмыг ЗГ-ын тогтоол, эсхүл эдийн засгийн онцгой бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох салбарын сайд, орон нутгийн удирдлагын шийдвэрээр хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй нь олон улсын жишээнүүдээс харж болно.

Манай улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчин дэлхийн чиг хандлагын дагуу бүрдсэн боловч зарим асуудал зохицуулагдаагүй байна. Уг асуудлыг хуулиар зохицуулахаас илүүтэйгээр тухайн бүс нутагт тохирсон, хүн ам, газар нутгийн байршил зэргээс хамааран журмаар зохицуулах боломжтой байж болно. Тодруулбал, чөлөөт бүсийн үйл ажиллагаанд төлбөр тооцоог гүйцэтгэх валют, тээвэр ложистикийн төв байгуулах талаар хууль, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай.

Аливаа бизнесийн гол хүчин түлхүүр нь мөнгө, бараа, ачааны тээвэр ложистик байдаг. Монгол улсын Автотээврийн тухай хууль, Банкны тухайн хуулиудад чөлөөт бүсэд үйлчлэх нөхцөлийг тусгайлан заагаагүйгаас гадна санхүүгийн үйлчилгээг гадны эсхүл дотоодын банз, санхүүгийн байгууллагын алинаар нь гүйцэтгүүлэх зэрэг нь тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Тодруулбал, логистикийн салбарын тухай суурь хууль, логистикийн салбарыг сайжруулах, логистикийн үйлчилгээг өндөр түвшинд хүргэх, логистикийн байгууламжийг барихтай холбоотой тусдаа хууль байхгүй.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Чөлөөт бүсэд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулахад эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэнэ. Харин гадаад улсын банк, санхүүгийн нэгдлээс Монгол Улсад салбар, нэгжээ нээн үйл ажиллагаа явуулах асуудлыг шийдвэрлэхдээ Монгол улсын санхүүгийн салбар, эдийн засгийн тогтвортой байдалд учруулах эрсдэл, эерэг, сөрөг нөлөөллүүд болон ирээдүйн бусад үр дагавруудыг харгалзан үзэж шийдвэрлэх нь зүйтэй.

2. Аль ч улсын банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан гүйлгээ хийх тохиолдолд тухайн гүйлгээний тодорхой хувийг үндэсний мөнгөн тэмдэгтээр буюу төгрөгөөр гүйцэтгэх зохицуулалтыг тусгах

3. FinTech, цахим арилжаа (e-commerce), цахим төлбөр тооцооны системүүдийг бий болгоход хөрөнгө оруулагч нар нэмэлт хөнгөлөлт эдлүүлж санхүүгийн либералчлалыг баримталж ажиллах. Ингэснээр нэг санхүүгийн байгууллагаас хамааралтай биш, түргэн шуурхай төлбөр тооцоог бүх валют, крипто мөнгөөр хийх боломж бүрдэнэ.

4. Логистикийн салбарыг сайжруулах болон байгууламжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор олон улсад нийцсэн хууль гаргах

5. Цахим худалдааны дэвшил нэмэгдэж байгаатай холбоотойгоор дотоодын логистикийн сүлжээ байгуулах эрэлт өссөн тул логистикийн технологи ба бизнесийн загварын талаарх хөрөнгө оруулалтыг идэвхижүүлэх

6. Дижитал технологид суурилсан ухаалаг логистикийн технологийг хөгжүүлэх, зөвхөн тээвэрлэх биш хангах сүлжээг бий болгоход бодлогоор дэмжих

7. Логистикийн компаниуд хоорондоо нэгдэхийг дэмжих, логистикийн компанийг өргөжүүлэх

8. Логистикийн салбарын дунд болон урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, чөлөөт бүс дэх логистикийн төлөвлөгөөг боловсруулж, хөрөнгө оруулалт татах арга замыг хайх

9. Чөлөөт бүсэд логистикийн үйлчилгээ үзүүлдэг холимог логистикийн цогцолбор байгуулах, агуулахын үйл ажжиллагааг нэгтгэн тоо хэмжээ, хадгалах байршлыг хянах, удирдах зохион байгуулах

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг.Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж

- 1.1.Монгол Улсын Үндсэн хууль;
- 1.2.Чөлөөт бүсийн тухай хууль;
- 1.3.Авто замын тухай хууль;
- 1.4.Төв банкны тухай хууль;
- 1.5.Банкны тухай хууль.

Хоёр.Олон улсын гэрээ

- 2.1.1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр;
- 2.2.Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр;
- 2.3.Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр.

Гурав. Бодлогын баримт бичиг

- 3.1.Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг;
- 3.2.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- 3.3.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- 3.4.Монгол Улсад Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал;
- 3.5. “Талын зам” үндэсний хөтөлбөр.

Дөрөв.Ном товхимол, судалгааны бүтээл

- 4.1. Д.Батсүх, “Олон улсын худалдаа, чөлөөт бүс ба гадаадын хөрөнгө оруулалт”, Улаанбаатар хот, 2006 он, “Шувуун саарал” ТӨААТҮГ;
- 4.2. Тао Итао, Лу Жигуо, “Эдийн засгийн онцгой бүс ба Хятадын зам”, (“ISB RUBY паблишинг” ХХК, 2021 он;
- 4.3. Зам тээвэр, логистикийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгаа, 2018 он
- 4.4. Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн судалгааны тойм, МУИС, 2017 он

Тав.Захиргааны хэм хэмжээ тогтоосон акт

- 5.1.Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам;
- 5.2.Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм;

- 5.3. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих журам;
- 5.4. Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журам;
- 5.5. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам;
- 5.6. Чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зорчигчийн худалдаж авсан 3 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалт;
- 5.7. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, заавар, гэрээний загвар;
- 5.8. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээ;
- 5.9. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам;
- 5.10. Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам;
- 5.11. Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам;
- 5.12. Чөлөөт бүсэд эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох журам;
- 5.13. Чөлөөт бүсэд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам.

Зургаа.Цахим хуудас

- 6.1 Замын-Үүдийн захирагчийн ажлын албаны цахим хуудас, <https://zfz.gov.mn/>;
- 6.2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, www.legalinfo.mn;
- 6.3. БНХАУ-ын Худалдааны яамны цахим хуудас, www.mofgov.gov.cn;
- 6.4. Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийн захиргааны цахим хуудас, www.zjsfq.gov.cn;
- 6.5. Дэлхийн худалдаан байгууллагын цахим хуудас, www.wto.org;
- 6.6. БНХАУ-ны нэг цонхны үйлчилгээ үзүүлэх цахим хуудас, www.singlewindow.cn

Долоо.Гадаад эх сурвалж

- 7.1. “Regulations on Special Economic Zones in Guangdong Province”, the 15th Meeting of the Standing Committee of the Fifth National People's Congress on August 26, 1980;

7.2. “A Comparative Analysis of Free Trade Zone Policies in Taiwan and Korea based on a Port Hinterland Perspective”, Yi-Chih YANG, The Asian Journal of Shipping and Logistics, December 2009;

7.3. “Financial Services Liberalization in the China (Shanghai) Pilot Free Trade Zone: Reflections on Regulations and Regulators”, Kim VAN DER BORGHT WANG Qian ZHANG Ji;

7.4. LAW AND POLICY OF CHINA'S SPECIAL ECONOMIC ZONES AND COASTAL CITIES, Henry R. Zheng, NYLS Journal of International and Comparative Law, Vol. 8 : No. 2 , Article 2;

7.5. 中华人民共和国 “一带一路”倡议;

7.6. General agreement on tariffs and trade, WTO, 1947;

7.7. International convention on the simplification and harmonization of customs procedures, 1973, WCO, Kyoto Convention;

7.8. Law on special economic and industrial zones in the Republic of Kazakhstan;

7.9. Special Economic Zone Act of The Philippines;

7.10. Free trade agreement between the government of the people’s republic of China and the government of the republic of Singapore, 2010;

